



2017 оны 02 дугаар сарын 17
№ 07 /964/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

Монгол Улсын
хууль

197

Монгол Улсын
хууль

235

Монгол Улсын
хууль

280

Арбитрын тухай
/Шинэчилсэн найруулга/

Гамшгаас хамгаалах тухай
/Шинэчилсэн найруулга/

Онц байдлын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай

ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | |
|-----|--|-----|
| 71. | Арбитрын тухай /Шинэчилсэн найруулга/ | 197 |
| 72. | Арбитрын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 221 |
| 73. | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай | 222 |
| 74. | Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 225 |
| 75. | Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 226 |
| 76. | Гэрээг харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 226 |
| 77. | Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 226 |
| 78. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 227 |
| 79. | Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 227 |
| 80. | Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 228 |
| 81. | Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 228 |
| 82. | Векселийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 229 |
| 83. | Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 229 |
| 84. | Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай | 230 |
| 85. | Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 230 |
| 86. | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 231 |



| | | |
|------|--|-----|
| 87. | Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 232 |
| 88. | Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 233 |
| 89. | Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 233 |
| 90. | Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 234 |
| 91. | Гамшгаас хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ | 235 |
| 92. | Гамшгаас хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | 268 |
| 93. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 269 |
| 94. | Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 269 |
| 95. | Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 269 |
| 96. | Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 270 |
| 97. | Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 270 |
| 98. | Архивын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 271 |
| 99. | Бага, дунд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 271 |
| 100. | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 272 |
| 101. | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 272 |
| 102. | Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 272 |
| 103. | Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 273 |

| | | |
|------|---|-----|
| 104. | Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 273 |
| 105. | Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 274 |
| 106. | Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 274 |
| 107. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 275 |
| 108. | Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 275 |
| 109. | Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 276 |
| 110. | Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 276 |
| 111. | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 277 |
| 112. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 277 |
| 113. | Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 278 |
| 114. | Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 278 |
| 115. | Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 279 |
| 116. | Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 279 |
| 117. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 280 |
| 118. | Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 280 |
| 119. | Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 280 |



| | | |
|------|---|-----|
| 120. | Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 281 |
| 121. | Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 281 |
| 122. | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 282 |
| 123. | Улсын нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 282 |
| 124. | Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 283 |
| 125. | Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 283 |
| 126. | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 284 |
| 127. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 284 |
| 128. | Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 284 |
| 129. | Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 285 |
| 130. | Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 285 |
| 131. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 286 |
| 132. | Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай | 286 |
| 133. | Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай | 287 |
| 134. | Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай | 287 |
| 135. | Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 288 |
| 136. | Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 288 |



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

АРБИТРЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг олон улсын стандартад нийцүүлэн зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

2.1.Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс бол энэ хууль үйлчилнэ.

2.2.Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улсаас өөр улс, эсхүл тодорхойлогдоогүй байсан ч арбитрын ажиллагаанд энэ хуулийн 10, 11, 27, 28, 29, 39, 48, 49 дүгээр зүйл үйлчилнэ.

3 дугаар зүйл.Арбитрын ажиллагаа

3.1.Арбитрын ажиллагаа гэдэгт байнгын, эсхүл түр арбитраас явуулж байгаа арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг ойлгоно.

3.2.Олон улсын арбитрын ажиллагаанд дараахь арбитрын ажиллагаа хамаарна:

3.2.1.арбитрын хэлэлцээр байгуулах үед уг хэлэлцээрийн талууд өөр өөр улсад үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

3.2.2.арбитрын хэлэлцээрт заасан, эсхүл түүнд тодорхойлсон арбитрын ажиллагааны харьяалал нь талуудын үйл ажиллагаа явуулж байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

3.2.3.арилжааны харилцаанаас үүсэх үүргийн ихэнхийг гүйцэтгэх газар, эсхүл маргааны зүйлтэй илүү холбоотой газар нь талуудын үйл ажиллагаа явуулж байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;



3.2.4.арбитрын хэлэлцээрээс үүсэх харилцаа нэгээс олон улсад хамаарна гэдгийг талууд тодорхой тохиролцсон тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа.

3.3.Энэ хуулийн 3.2-т заасныг тодорхойлохдоо:

3.3.1.аль нэг тал үйл ажиллагаагаа хэд хэдэн газар явуулдаг бол арбитрын хэлэлцээрт илүү холбоотойг нь үйл ажиллагаа явуулж байгаа газар гэж үзнэ;

3.3.2.аль нэг тал үйл ажиллагаа явуулдаг газаргүй бол түүний байнгын оршин байгаа газрыг үйл ажиллагаа явуулж байгаа газар гэж үзнэ.

3.4.Дотоодын арбитрын ажиллагаа гэж олон улсын арбитрын ажиллагаанаас бусад арбитрын ажиллагааг ойлгоно.

4 дүгээр зүйл.Баримт бичгийг хүлээн авсанд тооцох

4.1.Баримт бичгийг хүргэсэн өдрийг түүнийг хүлээн авсан өдөр гэж үзнэ.

4.2.Талууд өөрөөр тохиролцоогүй бол дараахь нөхцөлд баримт бичгийг хүлээн авсанд тооцно:

4.2.1.аливаа баримт бичгийг хүлээн авагч талд биечлэн хүргэсэн, эсхүл түүний үйл ажиллагаа явуулдаг, эсхүл байнга оршин байгаа /оршин суугаа/ газарт, эсхүл шуудангийн хаягаар хүргэсэнээр;

4.2.2.шаардлагатай бүхий л арга хэмжээг авсан боловч энэ хуулийн 4.2.1-д заасан хаягийг тогтоох боломжгүй бол баримт бичгийг хүлээн авагчийн хамгийн сүүлд үйл ажиллагаа явуулж байсан, эсхүл оршин байсан /оршин сууж байсан/, түүнчлэн хамгийн сүүлд мэдэгдэж байсан хаягаар нь баталгаат шуудангаар, мөн тийнхүү хүргүүлэх шаардлагатай арга хэмжээ авч байсныг баталгаажуулсан бусад аргаар илгээсэнээр.

4.3.Энэ хуулийн 4.1, 4.2 дахь хэсэг нь шүүхийн ажиллагаанд хамаарахгүй.

5 дугаар зүйл.Гомдол гаргах эрхээсээ татгалзах

5.1.Аль нэг тал нь энэ хуульд зааснаас өөрөөр талууд тохиролцож болох боломжтой заалтын талаар, эсхүл арбитрын хэлэлцээрийн аль нэг шаардлагыг биелүүлээгүй болохыг мэдэж байсан боловч тэр тухай

даруй, эсхүл тогтоосон хугацааны дотор гомдол гаргалгүйгээр арбитрын ажиллагаанд үргэлжлүүлэн оролцсон бол түүнийг гомдол гаргах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

6 дугаар зүйл.Шүүхийн оролцоо

6.1.Шүүх энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд арбитрын ажиллагаанд оролцож үл болно.

6.2.Энэ хуулийн 11.1, 13.4, 13.5, 15.3, 16.1, 18.7, 39.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлд заасан шүүхийн чиг үүргийг арбитрын ажиллагаа явагдсан газрын иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, харин олон улсын арбитрын ажиллагааны хувьд нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хэрэгжүүлнэ.

6.3.Энэ хуулийн 27, 29, 48, 51 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хариуцагчийн оршин суугаа газрын, эсхүл түүний эд хөрөнгө нь байгаа газрын иргэний хэргийн анхан шатны шүүх хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл.Арбитрын төрөл

7.1.Арбитр нь байнгын, эсхүл түр байж болно.

7.2.Байнгын арбитр нь арбитрын ажиллагааны дүрэмтэй байна. Байнгын арбитр нь энэ хуулийн 13.4, 16.1-д заасан хүсэлтийг эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болно.

7.3.Монгол Улсад байнгын арбитрыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, худалдаа үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан байнгын арбитр нь арбитрын ажиллагааг явуулах байр, хүний нөөцтэй байна.

7.5.Түр арбитрыг талуудын харилцан тохиролцсон журмын дагуу байгуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ АРБИТРЫН ХЭЛЭЛЦЭЭР

8 дугаар зүйл.Арбитрын хэлэлцээр, түүний хэлбэр

8.1.Арбитрын хэлэлцээр гэж гэрээний үндсэн дээр үүссэн эсэхээс үл хамааран бий болсон эрх зүйн харилцаатай холбоотойгоор талуудын



хооронд үүссэн, эсхүл үүсч болох аливаа маргаан, эсхүл түүний тодорхой хэсгийг арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай талуудын тохиролцоог хэлнэ.

8.2.Арбитрын хэлэлцээр нь гэрээний нэг хэсэг, эсхүл бие даасан гэрээ байж болно.

8.3.Арбитрын хэлэлцээрийг бичгээр хийнэ.

8.4.Арбитрын хэлэлцээрийг амаар, бодит үйлдлээр, эсхүл бусад арга хэрэгслээр хийснээс үл хамааран түүний агуулгыг ямар нэг хэлбэрээр баримтжуулсан бол бичгээр байгуулсан гэж үзнэ.

8.5.Цахим харилцаа холбоонд агуулагдсан мэдээлэлд нэвтэрч, түүнийг ашиглах боломжтой бол энэ хуулийн 8.3-т заасан шаардлагыг мэдээллийн өгөгдөл солилцох хэлбэрээр хангасанд тооцно.

8.6.Цахим харилцаа холбоо гэдэгт талууд хоорондоо мэдээллийн өгөгдөл ашигласан аливаа харилцааг ойлгоно.

8.7.Мэдээллийн өгөгдөл гэдэгт цахим, соронзон, гэрлийн болон бусад ижил төстэй арга хэлбэрээр бий болгосон, илгээсэн, хүлээн авсан, эсхүл хадгалсан мэдээлэл, цахим өгөгдөл солилцоо, цахим шуудан, цахилгаан, телексийг ойлгоно.

8.8.Нэхэмжлэл болон хариу тайлбарт арбитрын хэлэлцээр байгаа талаар тусгаж, нөгөө тал нь түүнийг үгүйсгээгүй бол арбитрын хэлэлцээрийг бичгээр үйлдсэн гэж үзнэ.

8.9.Арбитрын тухай заалт бүхий ямар нэг баримт бичгийг талуудын хооронд байгуулсан гэрээнд эш татсан бөгөөд энэ нь тухайн гэрээний хэсэг болохыг гэрээнд тусгайлан заасан бол үүнийг арбитрын хэлэлцээр гэж үзнэ.

8.10.Талуудын хооронд байгуулсан үндсэн гэрээ хүчин төгөлдөр эсэх, аль нэг тал нь гэрээнээс татгалзсан, эсхүл үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон эсэхээс үл хамааран түүний хэсэг болох арбитрын хэлэлцээр хүчинтэй байна.

8.11.Хэрэглэгчийн эрхтэй холбоотой маргааны тухайд арбитрын хэлэлцээрийг гагцхүү маргаан үүссэний дараа талууд бичгээр тусад нь байгуулах бөгөөд арбитрын ажиллагааны харьяаллыг заасан байна.



9 дүгээр зүйл.Арбитрын харьяаллын маргаан

9.1.Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл.Арбитрын хэлэлцээр ба шүүхэд нэхэмжлэл гаргах

10.1.Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд аль нэг тал тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бол шүүх аль нэг талын хүсэлтээр арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус, эсхүл биелүүлэх боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд арбитр нь шүүхийн ажиллагаа явагдаж байх хугацаанд арбитрын ажиллагааг эхлүүлэх, эсхүл үргэлжлүүлэх, арбитрын үндсэн шийдвэр гаргах эрхтэй.

11 дүгээр зүйл.Арбитрын хэлэлцээр ба шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахаар шүүхээс авах арга хэмжээ

11.1.Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө, эсхүл уг ажиллагааны явцад арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах энэ хуулийн 19.2-т заасан арга хэмжээ авахуулахаар шүүхэд хүсэлт гаргасан, шүүх уг хүсэлтийг хангасан шийдвэр гаргасан нь арбитрын хэлэлцээрийг зөрчсөнд тооцогдохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ АРБИТРЫН БҮРЭЛДЭХҮҮН, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

12 дугаар зүйл.Арбитрын бүрэлдэхүүн

12.1.Арбитрын бүрэлдэхүүн гэж тухайн маргааныг шийдвэрлэх нэг, эсхүл хэд хэдэн арбитрчийг ойлгоно.

12.2.Талууд арбитрчийн тоог харилцан тохиролцож тогтоох эрхтэй.

12.3.Талууд арбитрчийн тоог тохиролцоогүй бол тухайн маргаанд арбитрын ажиллагаа явуулах арбитрчийн тоо гурав байна.

13 дугаар зүйл. Арбитрчийг томилох журам

13.1. Талууд дараахь шаардлагыг хангасан этгээдийг арбитрчаар томилж болно:

13.1.1. талуудын харилцан тохиролцож тогтоосон мэргэжил, ур чадварын тусгай шаардлагад нийцсэн;

13.1.2. хараат бус, бие даасан байх;

13.1.3. өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглосон хуулийн шаардлагыг зөрчөөгүй байх.

13.2. Талууд өөрөөр тохиролцоогүй бол хэнийг ч иргэний харьяаллаас нь шалтгаалж арбитрчаар томилохоос татгалзаж болохгүй.

13.3. Талууд энэ хуулийн 13.5, 13.6, 13.7, 13.8-д зааснаас бусад тохиолдолд арбитрчийг томилох журмыг харилцан тохиролцож тогтоох эрхтэй.

13.4. Талууд арбитрчийг томилох журмыг тохиролцоогүй бол дараахь журмыг баримтална:

13.4.1. арбитрын ажиллагаанд гурван арбитрч оролцох бол тал тус бүр нэг арбитрчийг томилох ба томилогдсон хоёр арбитрч гурав дахь арбитрчийг томилно. Арбитрч томилох тухай хүсэлтийг нөгөө талаас хүлээн авсан тал тийнхүү хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитрчаа томилоогүй, эсхүл хоёр арбитрч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор гурав дахь арбитрчийг томилох талаар тохиролцоонд хүрээгүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрчийг шүүх, эсхүл талуудын сонгосон арбитрын дүрэмд заасан, эсхүл талуудын тохиролцсон эрх бүхий этгээд /цаашид “эрх бүхий этгээд” гэж/ томилно;

13.4.2. арбитрын ажиллагаанд нэг арбитрч оролцох үед талууд арбитрчийг томилох талаар тохиролцоонд хүрээгүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрчийг шүүх, эсхүл эрх бүхий этгээд томилно.

13.5. Талууд арбитрчийг томилох журмыг харилцан тохиролцсон боловч дараахь нөхцөлийн аль нэг үүссэн бөгөөд арбитрчийг томилох өөр аргыг уг журамд заагаагүй бол аль нэг тал арбитрч томилуулах хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй:

13.5.1. аль нэг тал арбитрчийг томилох үүргээ биелүүлээгүй;

13.5.2. талууд, эсхүл тэдгээрийн томилсон хоёр арбитрч гурав дахь арбитрчийг томилох талаар тохиролцоонд хүрч чадаагүй;

13.5.3. арбитрчийг томилох журмаар эрх олгосон байнгын арбитр, эсхүл эрх бүхий этгээд арбитрчийг томилох үүргээ хэрэгжүүлээгүй.

13.6. Энэ хуулийн 13.4, 13.5-д заасан асуудлаар гаргасан шийдвэр эцсийн шийдвэр байна.

13.7. Шүүх арбитрчийг томилохдоо арбитрын хэлэлцээрт заасан шаардлагыг харгалзах бөгөөд арбитрчийн хараат бус, бие даасан байх шаардлага хангасан этгээдийг арбитрчаар томилно.

13.8. Шүүх олон улсын арбитрын маргааны хувьд маргааныг дангаар шийдвэрлэх арбитрч, эсхүл гурав дахь арбитрчийг томилохдоо боломжтой бол талуудаас өөр иргэншилтэй арбитрчийг томилно.

14 дүгээр зүйл. Арбитрчийг татгалзан гаргах үндэслэл

14.1. Арбитрчаар томилогдох этгээд өөрийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл бүхий нөхцөл байдлын талаар мэдэгдэх үүрэгтэй. Арбитрч дээр дурдсан нөхцөл байдлын талаар талуудад өмнө нь мэдэгдээгүй бол арбитрчаар томилогдсоноос хойш арбитрын ажиллагааны явцад тэрхүү нөхцөл байдлын талаар талуудад даруй мэдэгдэнэ.

14.2. Арбитрчийг гагцхүү хуулиар тогтоосон болон талуудын тохиролцсон мэргэжил, ур чадварын шаардлагад нийцээгүй, эсхүл арбитрчийн хараат бус, бие даасан байдалд эргэлзээ төрүүлэхүйц үндэслэл бүхий нөхцөл байдал байгаа үндэслэлээр татгалзан гаргана.

14.3. Аль нэг тал өөрийн томилсон, эсхүл томилоход оролцсон арбитрчийг татгалзан гаргах үндэслэл байгааг түүнийг томилсныхоо дараа мэдсэн тохиолдолд татгалзан гаргаж болно.

15 дугаар зүйл. Арбитрчийг татгалзан гаргах журам

15.1. Энэ хуулийн 15.3-т зааснаас бусад тохиолдолд талууд арбитрчийг татгалзан гаргах журмыг тохиролцож болно.

15.2. Талууд арбитрчийг татгалзан гаргах журмыг тохиролцоогүй бол арбитрчийг татгалзах хүсэлтэй байгаа тал арбитрын бүрэлдэхүүний талаар, эсхүл энэ хуулийн 14.2-т заасан нөхцөл байдлын талаар мэдсэнээс хойш 14 хоногийн дотор татгалзан гаргах хүсэлтээ бичгээр



үйлдэн арбитрын бүрэлдэхүүнд хүргүүлнэ. Татгалзан гаргах хүсэлтэд нэр дурдсан арбитрч өөрийн хүсэлтээр үүргээсээ чөлөөлөгдсөн, эсхүл нөгөө тал татгалзлыг хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд татгалзан гаргах хүсэлтийг бичгээр хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасан, эсхүл талуудын тохиролцсон журмын дагуу татгалзан гаргах хүсэлтийг хангаагүй бол хүсэлт гаргасан тал шийдвэрийг хүлээн авснаас хойш олон улсын арбитрын ажиллагааны хувьд 30 хоногийн дотор, дотоодын арбитрын ажиллагааны хувьд 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно. Уг гомдлыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна. Шүүхэд гаргасан тухайн гомдлыг шийдвэрлэж дуусах хүртэл татгалзан гаргах хүсэлтэд нэр заасан арбитрчийг оролцуулан арбитрын бүрэлдэхүүн маргаан шийдвэрлэх ажиллагаагаа үргэлжлүүлж, үндсэн шийдвэр гаргаж болно.

16 дугаар зүйл. Арбитрч үүргээ гүйцэтгэж чадахгүй, эсхүл гүйцэтгэх боломжгүй болох

16.1. Арбитрч бодит шалтгааны улмаас, эсхүл хууль зүйн хувьд үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон, эсхүл бусад шалтгаанаар үүргээ тасралтгүй гүйцэтгэж чадахгүй болсон үндэслэлээр өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, эсхүл талууд түүнийг үүргээс нь чөлөөлөхөөр тохиролцсон бол түүний бүрэн эрх дуусгавар болно. Эдгээр үндэслэл эргэлзээ төрүүлэхүйц байгаа бол аль нэг тал арбитрчийн бүрэн эрхийг дуусгавар болгох талаар шүүх, эсхүл эрх бүхий этгээдэд хүсэлт гаргаж болох бөгөөд хүсэлтийг шийдвэрлэсэн шийдвэр эцсийн шийдвэр байна.

16.2. Энэ хуулийн 15.2, 16.1-д заасны дагуу арбитрч өөрөө үүргээсээ чөлөөлөгдсөн, эсхүл талууд бүрэн эрхийг нь дуусгавар болгохоор тохиролцсоныг энэ хуулийн 14.2, 16.1-д заасан үндэслэлийг нотолсон гэж тооцохгүй.

17 дугаар зүйл. Арбитрчийг нөхөн томилох

17.1. Энэ хуулийн 15, 16 дугаар зүйлд заасан болон бусад үндэслэлээр арбитрчийн бүрэн эрх дуусгавар болсон бол шинэ арбитрчийг өмнөх арбитрчийг томилсон журмын дагуу нөхөн томилно.

18 дугаар зүйл. Маргааны харьяалал тогтоох талаархи арбитрын бүрэлдэхүүний эрх

18.1. Арбитрын бүрэлдэхүүн тухайн маргаан нь арбитрын харьяаллын маргаан мөн эсэх, талууд арбитрын хэлэлцээртэй эсэх, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эсэхийг өөрөө тогтооно.

18.2.Тухайн гэрээн дэх арбитрын тухай заалтыг үндсэн гэрээний бусад заалтаас тусдаа, бие даасан гэрээ гэж үзнэ. Арбитрын бүрэлдэхүүн үндсэн гэрээг хүчин төгөлдөр бус гэж шийдвэр гаргасан нь тэрхүү гэрээний арбитрын тухай заалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй.

18.3.Талууд маргааны харьяаллын талаар гомдол гаргах бол нэхэмжлэлд тайлбар гаргахаасаа өмнө тухайн арбитрын бүрэлдэхүүнд гаргана. Арбитрчийг томилоход оролцсон нь арбитрын маргааны харьяаллын талаар гомдол гаргах эрхийг хязгаарлахгүй.

18.4.Талууд арбитрын ажиллагааны явцад арбитрын бүрэлдэхүүн эрх хэмжээгээ хэтрүүлж байна гэж үзвэл энэ тухай гомдлыг тухайн арбитрын бүрэлдэхүүнд даруй гаргана.

18.5.Энэ хуулийн 18.3, 18.4-т заасан гомдлыг хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж арбитрын бүрэлдэхүүн үзвэл гомдлыг хэдийд ч хүлээн авч болно.

18.6.Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 18.3, 18.4-т заасан гомдлын талаар тогтоол гаргах, эсхүл энэ тухай үндсэн шийдвэртээ тусгана.

18.7.Талууд арбитрын харьяаллын талаар гаргасан арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болох ба тухайн шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна.

18.8.Шүүхийн ажиллагаа явагдаж байх хугацаанд арбитрын бүрэлдэхүүн арбитрын ажиллагааг үргэлжлүүлж, үндсэн шийдвэр гаргаж болно.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
АРБИТРААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ
БАТАЛГААЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ,
УРЬДЧИЛСАН ТОГТООЛ**

**19 дүгээр зүйл.Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах
талаархи арбитрын бүрэлдэхүүний бүрэн эрх**

19.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрын бүрэлдэхүүн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авч болно.



19.2. Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ /цаашид “түр арга хэмжээ” гэх/ гэдэгт маргааныг эцэслэн шийдвэрлэхээс өмнө үндсэн шийдвэрээр, эсхүл бусад хэлбэрээр аль нэг талд үүрэг болгосон дараахь хүрээнд авах түр арга хэмжээ хамаарна:

19.2.1. маргааныг эцэслэн шийдвэрлэх хүртэл одоогийн байгаа нөхцөл байдлаа хэвээр хадгалах, эсхүл сэргээх;

19.2.2. одоогийн, эсхүл учирч болох хохирлыг нэмэгдүүлэх, эсхүл арбитрын ажиллагаанд бэрхшээл учруулах үйлдэл хийхгүй байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

19.2.3. арбитрын үндсэн шийдвэрийн биелэлтийг хангахад шаардлагатай байж болох хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах;

19.2.4. маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой, уг маргаантай холбоотой байж болох нотлох баримтыг хамгаалах.

20 дугаар зүйл. Түр арга хэмжээ авах нөхцөл

20.1. Энэ хуулийн 19.2.1, 19.2.2, 19.2.3-т заасан түр арга хэмжээ авах тухай хүсэлт гаргасан тал дараахь нөхцөлийг нотолно:

20.1.1. тухайн арга хэмжээг аваагүй тохиолдолд үндсэн шийдвэрийн дагуу төлүүлж болох хохирлыг хангалттай барагдуулах боломжгүй бөгөөд уг хохирлын хэмжээ нь тухайн арга хэмжээг авсны улмаас уг арга хэмжээнд холбогдох этгээдэд учирч болох хохирлоос үлэмж их байх;

20.1.2. маргааныг хүсэлт гаргагч талд ашигтайгаар шийдвэрлэх үндэслэлтэй магадлал байгаа;

20.1.3. энэ хуулийн 19.2-т заасан түр арга хэмжээг авахуулах хүсэлт тодорхой, ойлгомжтой, хэрэгжихүйц байх.

20.2. Энэ хуулийн 20.1.2-т заасан магадлалыг тогтоох нь цаашид шийдвэр гаргах арбитрын бүрэлдэхүүний дотоод итгэл үнэмшилд нөлөөлөхгүй.

20.3. Гагцхүү арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзсэн бол энэ хуулийн 19.2.4-т заасан арга хэмжээ авахуулах тухай хүсэлтэд энэ хуулийн 20.1.1, 20.1.2-т заасан нөхцөл нэгэн адил хамаарна.

21 дүгээр зүйл. Урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл, урьдчилсан тогтоол гаргах нөхцөл

21.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэг тал нь бусад талдаа мэдэгдэхгүйгээр түр арга хэмжээ авахуулах тухай хүсэлтээ тухайн арга хэмжээний зорилгод хүрэхэд саад учруулахгүй байхыг үүрэг болгосон урьдчилсан тогтоол гаргуулах өргөдөлд хавсаргаж болно.

21.2. Түр арга хэмжээ авах тухай нэг талын хүсэлтийг уг хүсэлтэд холбогдох нөгөө талд урьдчилан мэдэгдэх нь уг арга хэмжээний зорилгод саад учруулах эрсдэлтэй гэж арбитрын бүрэлдэхүүн үзсэн бол урьдчилсан тогтоол гаргаж болно.

21.3. Энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан нөхцөл нь урьдчилсан тогтоолд нэгэн адил хамаарах бөгөөд энэ хуулийн 20.1.1-д заасны дагуу тооцох хохирол нь уг тогтоолыг гаргах эсэхээс шалтгаалах хохирол байна.

22 дугаар зүйл. Урьдчилсан тогтоол гаргах тусгай журам

22.1. Арбитрын бүрэлдэхүүн урьдчилсан тогтоол гаргуулах өргөдлийг шийдвэрлэсэн даруйдаа түр арга хэмжээ авах тухай хүсэлт, урьдчилсан тогтоол гаргуулах өргөдөл, урьдчилсан тогтоол гарсан бол уг тогтоолыг, үүнтэй холбоотойгоор арбитрын бүрэлдэхүүн аль нэг талтай амаар болон бусад хэлбэрээр харилцсан бүх мэдээллийг багтаасан мэдэгдлийг талуудад хүргүүлнэ.

22.2. Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 22.1-д заасан мэдэгдлийг өгөхийн зэрэгцээ урьдчилсан тогтоолоор үүрэг хүлээсэн талд боломжит хамгийн богино хугацаанд тайлбараа гаргах боломж олгоно.

22.3. Урьдчилсан тогтоолыг эс зөвшөөрсөн тайлбарыг арбитрын бүрэлдэхүүн даруй хэлэлцэн шийдвэрлэнэ.

22.4. Арбитрын бүрэлдэхүүний урьдчилсан тогтоол нь түүнийг гаргасан өдрөөс хойш 20 хоногийн дараа хүчингүй болно. Урьдчилсан тогтоолыг холбогдох талд мэдэгдэж, тайлбар өгөх боломж олгосны дараа арбитрын бүрэлдэхүүн урьдчилсан тогтоолыг хэвээр үлдээх, эсхүл өөрчилж түр арга хэмжээ авах тухай шийдвэр гаргаж болно.

22.5. Талууд урьдчилсан тогтоолыг заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд уг тогтоолыг шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан гүйцэтгэхгүй.

22.6. Урьдчилсан тогтоол нь арбитрын үндсэн шийдвэрт хамаарахгүй.

23 дугаар зүйл.Түр арга хэмжээ, урьдчилсан тогтоолыг өөрчлөх, түдгэлзүүлэх, дуусгавар болгох

23.1.Арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын өргөдлөөр, онцгой тохиолдолд талуудад мэдэгдсэний үндсэн дээр өмнө нь гаргасан шийдвэрийн биелэлт баталгаажуулах арга хэмжээ, эсхүл урьдчилсан тогтоолыг санаачилгаараа өөрчилж, түдгэлзүүлж, дуусгавар болгож болно.

24 дүгээр зүйл.Санхүүгийн баталгаа гаргуулах

24.1.Арбитрын бүрэлдэхүүн нь түр арга хэмжээ авах тухай хүсэлт гаргасан талд уг арга хэмжээтэй холбогдуулан зохих санхүүгийн баталгаа гаргахыг шаардаж болно.

24.2.Арбитрын бүрэлдэхүүн зохимжгүй, эсхүл шаардлагагүй гэж үзсэнээс бусад тохиолдолд урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл гаргасан талаас уг тогтоолтой холбогдуулан санхүүгийн баталгаа гаргахыг шаардана.

25 дугаар зүйл.Мэдээллийг ил болгох

25.1.Арбитрын бүрэлдэхүүн түр арга хэмжээ авах хүсэлт гаргах, уг хүсэлтийг хангах үндэслэл болсон нөхцөл байдалд бодит өөрчлөлт гарсан тохиолдолд энэ талаар даруй мэдээлэхийг аль ч талаас шаардаж болно.

25.2.Урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл гаргасан тал уг тогтоолыг гаргах, эсхүл түүнд өөрчлөлт оруулах тухай шийдвэрт хамааралтай байж болох аливаа нөхцөл байдлыг арбитрын бүрэлдэхүүнд мэдээлэх үүрэгтэй бөгөөд энэхүү үүрэг нь нөгөө тал тайлбараа гаргах хүртэл хугацаанд хэвээр хадгалагдана.

26 дугаар зүйл.Зардал, хохирлыг гаргуулах

26.1.Тухайн нөхцөл байдалд түр арга хэмжээ авах, урьдчилсан тогтоол гаргах шаардлагагүй байсныг арбитрын бүрэлдэхүүн хожим тогтоосон бол түүний улмаас аль нэг талын гаргасан зардал, учирсан хохирлыг уг түр арга хэмжээ авах тухай хүсэлт, урьдчилсан тогтоол гаргуулах тухай өргөдөл гаргасан тал хариуцна.

26.2.Арбитрын бүрэлдэхүүн нь маргаан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 26.1-д заасан зардал, хохирлыг нөхөн төлүүлэх тухай шийдвэр гаргаж болно.

27 дугаар зүйл.Түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх

27.1.Арбитрын бүрэлдэхүүнээс авсан түр арга хэмжээг талууд биелүүлэх үүрэгтэй.

27.2.Арбитрын бүрэлдэхүүн өөрөөр тогтоогоогүй бол энэ хуулийн 28 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд, уг түр арга хэмжээ авах шийдвэрийг гүйцэтгүүлэхээр аль улсад гарснаас үл хамааран харьяалах шүүхэд өргөдөл гаргаж болно.

27.3.Түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгүүлэх өргөдөл гаргасан, эсхүл түүнд дурдсан хүсэлтээ хангуулсан тал нь тухайн арга хэмжээг өөрчилсөн, түдгэлзүүлсэн, цуцалсан тухай харьяалах шүүхэд даруй мэдэгдэх үүрэгтэй.

27.4.Санхүүгийн баталгаа гаргах талаар арбитрын бүрэлдэхүүн шийдвэр гаргаагүй боловч энэ нь гуравдагч этгээдийн эрхийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай гэж шүүх үзвэл энэ хуулийн 27.2-т заасан хүсэлт гаргасан талд санхүүгийн баталгаа гаргах үүрэг хүлээлгэж болно.

28 дугаар зүйл.Түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэхээс татгалзах үндэслэл

28.1.Шүүх доор дурдсан аль нэг үндэслэлээр түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэхээс татгалзаж болно:

28.1.1.түр арга хэмжээгээр үүрэг хүлээсэн талын хүсэлтээр дараахь нөхцөлийн аль нэг нь байгаа гэж шүүх үзсэн:

28.1.1.а.энэ хуулийн 49.1.1.а, 49.1.1.б, 49.1.1.в, 49.1.1.г-д заасан үндэслэл байгаа;

28.1.1.б.түр арга хэмжээтэй холбогдуулан санхүүгийн баталгаа гаргах талаар арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг биелүүлээгүй;

28.1.1.в.тухайн арбитрын бүрэлдэхүүн, эсхүл эрх олгогдсон бол арбитрын ажиллагаа харьяалагдах газрын шүүх, эсхүл түр арга хэмжээ авах шийдвэр гаргасан улсын хуулиар уг шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг түдгэлзүүлсэн, цуцалсан.

28.1.2.шүүх дараахь нөхцөл байдлын аль нэгийг тогтоосон:



28.1.2.а.шүүх түр арга хэмжээний гүйцэтгэлийг хангах зорилгоор түүний үндсэн агуулгад өөрчлөлт оруулахгүйгээр өөрийн эрх хэмжээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамдаа нийцүүлэн түр арга хэмжээг өөрчлөн томьёолохоор шийдвэрлэснээс бусад тохиолдолд уг түр арга хэмжээ нь шүүхийн бүрэн эрхэд хамаарахгүй байгаа;

28.1.2.б.энэ хуулийн 49.1.2.а, 49.1.2.б-д заасан аль нэг үндэслэл нь түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэхэд хамаарч байгаа.

28.2.Энэ хуулийн 28.1-д заасан аль нэг үндэслэлээр шүүхээс гаргасан шийдвэр нь гагцхүү түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэхэд хүчин төгөлдөр үйлчилнэ. Түр арга хэмжээг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай өргөдөл хүлээн авсан шүүх нь шийдвэр гаргахдаа тухайн түр арга хэмжээний үндсэн агуулгыг хянахгүй.

29 дүгээр зүйл.Шүүхээс авах түр арга хэмжээ

29.1.Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс мөн эсэхээс үл хамааран арбитрын ажиллагаатай холбоотой асуудлыг хянан шийдвэрлэхдээ шүүх түр арга хэмжээ авч болно. Шүүх энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ олон улсын арбитрын ажиллагааны онцлогийг харгалзан үзнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ АРБИТРЫН АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

30 дугаар зүйл.Талуудын тэгш эрхийг хангах

30.1.Арбитрын ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох ба талууд өөрийн байр суурийг илэрхийлэх боломжоор бүрэн хангагдана.

31 дүгээр зүйл.Арбитрын ажиллагааны журам тогтоох

31.1.Талууд арбитрын ажиллагааны журмыг энэ хуулийн хүрээнд чөлөөтэй тохиролцон тогтооно.

31.2.Талууд арбитрын ажиллагааны журмыг тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн хүрээнд арбитрын ажиллагааг тохиромжтой гэж үзсэн журмаар явуулж болно. Арбитрын бүрэлдэхүүний бүрэн эрхэд аливаа нотлох баримтыг нотлох чадвартай, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв эргэлзээгүй болохыг тодорхойлох эрх хамаарна.

32 дугаар зүйл.Арбитрын ажиллагааны харьяалал

32.1.Арбитрын ажиллагааны харьяаллыг талууд тохиролцон тогтоох эрхтэй. Ийнхүү тохиролцон тогтоогоогүй бол арбитрын бүрэлдэхүүн талуудад чирэгдэлгүй байх зэрэг хэргийн нөхцөл байдлыг харгалзан арбитрын ажиллагааны харьяаллыг тодорхойлно.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасныг үл харгалзан, талууд өөрөөр тохиролцоогүй бөгөөд арбитрын бүрэлдэхүүн зохистой гэж үзсэн бол арбитрын бүрэлдэхүүн уулзаж зөвлөлдөх, гэрч, шинжээч, талуудын мэдүүлгийг сонсох, бараа бүтээгдэхүүн, эд хөрөнгө, баримт бичигт үзлэг хийх зэрэг ажиллагааг хаана ч явуулж болно.

33 дугаар зүйл.Арбитрын ажиллагаа эхлэх

33.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол тухайн маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай нэхэмжлэлийг хариуцагч хүлээн авсан өдрөөс арбитрын ажиллагаа эхэлнэ.

34 дүгээр зүйл.Арбитрын ажиллагаа явуулах хэл

34.1.Талууд арбитрын ажиллагаа явуулах нэг, эсхүл хэд хэдэн хэлийг тохиролцон тогтоох эрхтэй.

34.2.Арбитрын ажиллагаа явуулах хэлийг талууд тохиролцон тогтоогоогүй бол арбитрын бүрэлдэхүүн тодорхойлно.

34.3.Тохиролцох буюу тодорхойлохдоо өөрөөр заагаагүй бол талуудын тохиролцсон, эсхүл арбитраас тодорхойлсон хэл нь талуудын бичгээр үйлдсэн нэхэмжлэл, тайлбар, арбитрын хуралдаан, тогтоол, шийдвэр, үндсэн шийдвэр зэрэг арбитрын бүх ажиллагаанд хамаарна.

34.4.Арбитрын бүрэлдэхүүн аливаа бичмэл нотлох баримтыг талуудын тохиролцсон, эсхүл арбитрын бүрэлдэхүүнээс тодорхойлсон хэлээр орчуулан хавсаргахыг талуудаас шаардаж болно.

35 дугаар зүйл.Нэхэмжлэгчийн нэхэмжлэл, хариуцагчийн тайлбар

35.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болох үйл баримт, тайлбарыг, хариуцагч нь тэдгээртэй холбоотой тайлбараа зохих бүрдүүлбэрийн хамт талуудын тохиролцсон, эсхүл арбитрын бүрэлдэхүүнээс тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.



35.2.Талууд нэхэмжлэл, эсхүл тайлбартаа хэрэгт ач холбогдолтой гэж үзсэн нотлох баримтыг хавсаргах, эсхүл цаашид нэмж гаргаж өгөх баримт бичиг, бусад нотлох баримтын талаар дурдана.

35.3.Талууд өөрөөр тохиролцоогүй бөгөөд хүсэлтийг хугацаа хожимдуулж гаргасны улмаас хангах боломжгүй гэж арбитрын бүрэлдэхүүн үзсэнээс бусад тохиолдолд арбитрын ажиллагааны аль ч шатанд талууд нэхэмжлэл, эсхүл тайлбараа өөрчлөх, нэмэлт оруулах эрхтэй.

36 дугаар зүйл.Биечлэн оролцох арбитрын хуралдаан ба нотлох баримтад үндэслэн явуулах арбитрын ажиллагаа

36.1.Талуудын тохиролцоог зөрчихөөргүй бол арбитрын бүрэлдэхүүн нотлох баримтыг танилцуулах, мэтгэлцэхэд талуудыг биечлэн оролцуулж хуралдах, эсхүл арбитрын ажиллагааг цугларсан баримт бичиг, бусад баримт сэлтийг үндэслэн явуулах эсэхийг шийдвэрлэнэ.

36.2.Биечлэн оролцох хуралдаан хийхгүй байхаар талууд тохиролцооноос бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн аль нэг талын хүсэлтээр арбитрын ажиллагааны зохих шатанд биечлэн оролцох хуралдаан явуулах үүрэгтэй.

36.3.Бараа, бусад хөрөнгө, баримт бичгийг шинжлэн судлах зорилгоор хийх биечлэн оролцох хуралдаан, эсхүл арбитрын бүрэлдэхүүний уулзалтын талаархи мэдэгдлийг талуудад хангалттай хугацааны өмнө хүргүүлсэн байна.

36.4.Нэг талаас арбитрын бүрэлдэхүүнд ирүүлсэн тайлбар, баримт бичиг, бусад мэдээллийг нөгөө талд заавал хүргүүлнэ.

36.5.Арбитрын бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа үндэслэл болгож болох шинжээчийн дүгнэлт, бусад нотлох баримтыг талуудад мөн адил хүргүүлнэ.

37 дугаар зүйл.Талууд үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагавар

37.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бөгөөд тэдгээрийн үүргээ биелүүлээгүй нь хүндэтгэн үзэх шалтгаангүй гэж арбитрын бүрэлдэхүүн үзвэл дараахь арга хэмжээ авч болно:

37.1.1.нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээ энэ хуулийн 35.1-д заасан шаардлагад нийцүүлэн дэмжээгүй бол арбитрын ажиллагааг дуусгавар болгох;



37.1.2.хариуцагч хариу тайлбараа энэ хуулийн 35.1-д заасан шаардлагад нийцүүлэн ирүүлээгүй бол нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэхгүй бөгөөд арбитрын бүрэлдэхүүн маргаан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх;

37.1.3.аль нэг тал арбитрын хуралдаанд оролцоогүй, эсхүл шаардлагатай нотлох баримтыг ирүүлээгүй бол арбитрын ажиллагааг үргэлжлүүлж, цугларсан нотлох баримтад үндэслэн арбитрын шийдвэр гаргах.

38 дугаар зүйл.Арбитрын ажиллагаанд шинжээч оролцуулах

38.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн дараахь ажиллагааг явуулж болно:

38.1.1.арбитрын бүрэлдэхүүний тодорхойлсон асуудлаар дүгнэлт гаргуулахаар нэг, эсхүл хэд хэдэн шинжээч томилох;

38.1.2.тухайн маргаанд холбогдох мэдээллийг шинжээчид өгөх буюу бэлтгэж өгөх, холбогдох баримт бичиг, бараа бүтээгдэхүүн, бусад эд хөрөнгөд үзлэг шалгалт хийх боломжийг шинжээчид олгохыг аль нэг талаас шаардах.

38.2.Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзсэн, эсхүл аль нэг талын хүсэлтээр шинжээч арбитрын хуралдаанд оролцож, гаргасан дүгнэлтийнхээ талаар тайлбар хийж, талуудын асуултад хариулт өгөх үүрэгтэй.

39 дүгээр зүйл.Нотлох баримт бүрдүүлэхэд шүүх туслалцаа үзүүлэх

39.1.Арбитрын бүрэлдэхүүн, эсхүл түүний зөвшөөрснөөр талууд нотлох баримт гаргуулахад туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болох бөгөөд шүүх уг хүсэлтийг эрх хэмжээнийхээ хүрээнд хуульд заасан нотлох баримт гаргуулах журмын дагуу шийдвэрлэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭР ГАРГАХ, АРБИТРЫН АЖИЛЛАГАА ДУУСГАВАР БОЛОХ

40 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ

40.1.Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээг талууд харилцан тохиролцоо бөгөөд арбитрын бүрэлдэхүүн талуудын тохиролцсон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн тухайн маргааныг шийдвэрлэнэ.



40.2.Арбитрын бүрэлдэхүүн талуудын тохиролцсон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхдээ уг тохиролцоонд тусгайлан заагаагүй бол түүнийг тухайн улсын материаллаг эрх зүйн хэм хэмжээ гэж ойлгож хэрэглэх бөгөөд үүнд иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх хэм хэмжээ хамаарахгүй.

40.3.Маргаан шийдвэрлэхэд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээг талууд харилцан тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн тухайн маргааныг шийдвэрлэхэд аль тохиромжтой гэж үзсэн материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэнэ.

40.4.Талууд тусгайлан тохиролцож эрх олгосон бол арбитрын бүрэлдэхүүн аливаа хуулийг хэрэглэхгүйгээр шударга гэж үзсэн ёс зүйн хэм хэмжээг баримтлан, эсхүл эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг шийдвэрлэнэ.

40.5.Арбитрын бүрэлдэхүүн талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлд үндэслэн тухайн асуудлаар тогтож хэвшсэн худалдааны зан заншлыг харгалзан маргааныг шийдвэрлэнэ.

41 дүгээр зүйл.Арбитрын зардал

41.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол арбитрын зардлын хэмжээ, төлөх этгээд, төлбөрийн журмыг арбитрын бүрэлдэхүүн тогтооно.

41.2.Арбитрын зардалд дараахь зардал хамаарна:

41.2.1.арбитрчийн хөлс, зардал;

41.2.2.байнгын арбитрын хувьд түүний дүрэмд заасан тухайн арбитрт төлөх үйлчилгээний хөлс;

41.2.3.гэрч, шинжээч оролцуулах, хууль зүйн туслалцаа авах, шинжилгээ хийлгэх зэрэг арбитрын бусад ажиллагаа явуулахад гарсан хөлс, зардал.

42 дугаар зүйл.Арбитрын бүрэлдэхүүн шийдвэр гаргах

42.1.Арбитрын бүрэлдэхүүнд нэгээс илүү арбитрч оролцож байгаа тохиолдолд талууд өөрөөр тохиролцоогүй бол шийдвэрээ олонхийн саналаар гаргана.

42.2.Талууд, эсхүл арбитрын бүрэлдэхүүн санал нэгтэй зөвшөөрсөн бол арбитрын ажиллагааны явцад гарах горимын шинжтэй асуудлыг арбитрын хуралдаан даргалагч дангаараа шийдвэрлэж болно.

43 дугаар зүйл.Талууд эвлэрэх

43.1.Арбитрын ажиллагааны явцад талууд эвлэрсэн бол арбитрын бүрэлдэхүүн ажиллагааг дуусгавар болгох ба талууд ийнхүү хүсэлт гаргасныг арбитрын бүрэлдэхүүн татгалзаагүй бол эвлэрлийн нөхцөлийг арбитрын үндсэн шийдвэрт тусгаж баталгаажуулна.

43.2.Талууд эвлэрсэн тухай арбитрын үндсэн шийдвэр энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байх ба арбитрын үндсэн шийдвэр мөн болохыг уг шийдвэрт тусгайлан заана. Уг шийдвэр нь арбитрын үндсэн шийдвэрийн адил хүчин төгөлдөр хэрэгжинэ.

44 дүгээр зүйл.Арбитрын үндсэн шийдвэрийн хэлбэр, агуулга

44.1.Арбитрын үндсэн шийдвэрийг бичгээр үйлдэж, арбитрын бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Нэгээс илүү арбитрч оролцсон арбитрын бүрэлдэхүүний гаргасан шийдвэрт тэдгээрийн олонхи гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба аль нэг арбитрч гарын үсэг зураагүй бол шалтгааныг нь заана.

44.2.Талууд үндсэн шийдвэрийн үндэслэлийг заах шаардлагагүй гэж тохиролцсон, эсхүл энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаар эвлэрснээс бусад тохиолдолд арбитрын үндсэн шийдвэрт түүнийг гаргах болсон үндэслэлийг тодорхой заана.

44.3.Арбитрын үндсэн шийдвэрт маргаан шийдвэрлэсэн огноо болон энэ хуулийн 32.1-д зааснаар тодорхойлсон арбитрын ажиллагааны харьяаллыг заах бөгөөд үндсэн шийдвэрийг уг харьяаллын дагуу гаргасан гэж үзнэ.

44.4.Арбитрын үндсэн шийдвэр гарсны дараа энэ хуулийн 44.1-д заасны дагуу гарын үсэг зурсан хуулбарыг талуудад хүргүүлнэ.

45 дугаар зүйл.Арбитрын ажиллагаа дуусгавар болох

45.1.Арбитрын үндсэн шийдвэр, эсхүл энэ хуулийн 45.2-т заасан тогтоол гарснаар арбитрын ажиллагаа дуусгавар болно.

45.2.Арбитрын бүрэлдэхүүн дараахь тохиолдолд арбитрын ажиллагааг дуусгавар болгох тухай тогтоол гаргана:

45.2.1.нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан. Ийнхүү татгалзсаныг хариуцагч зөвшөөрөөгүй бөгөөд арбитрын бүрэлдэхүүн маргааныг эцэслэн шийдвэрлүүлэх хариуцагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрсөн бол энэ заалт хамаарахгүй;



45.2.2. талууд арбитрын ажиллагааг дуусгавар болгохоор тохиролцсон;

45.2.3. арбитрын бүрэлдэхүүн дээр дурдсанаас бусад шалтгаанаар маргаан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй, эсхүл шаардлагагүй болсон гэж үзсэн.

45.3. Арбитрын ажиллагаа дуусгавар болсноор тухайн арбитрын бүрэлдэхүүний энэ хуулийн 46 дугаар зүйл, 47.4-т зааснаас бусад бүрэн эрх дуусгавар болно.

46 дугаар зүйл. Арбитрын үндсэн шийдвэрт засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах

46.1. Талууд өөр хугацаа тогтоогоогүй бол арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор нэг тал нь нөгөө талдаа мэдэгдсэнээр арбитрын үндсэн шийдвэрийн үг үсэг, тооцоо, хэвлэлийн болон тэдгээртэй адилтгах бусад алдааг засуулах тухай арбитрын бүрэлдэхүүнд хүсэлт гаргаж болно.

46.2. Талууд тохиролцож нэг тал нь нөгөө талдаа мэдэгдсэнээр арбитрын үндсэн шийдвэрийн тодорхой хэсэг, зүйлийг тайлбарлуулах тухай хүсэлтийг талууд өөр хугацаа тогтоогоогүй бол арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитрын бүрэлдэхүүнд гаргаж болно.

46.3. Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 46.1, 46.2-т заасан хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор арбитрын үндсэн шийдвэрт зохих засвар оруулах, эсхүл холбогдох тайлбар хийнэ. Тайлбар нь арбитрын үндсэн шийдвэрийн бүрэлдэхүүн хэсэг байна.

46.4. Арбитрын бүрэлдэхүүн энэ хуулийн 46.1-д заасан алдааг үндсэн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор өөрийн санаачилгаар засч болно.

46.5. Талууд өөрөөр тохиролцоогүй бол аль нэг тал нь нөгөө талдаа мэдэгдэж, арбитрын ажиллагааны явцад хэлэлцсэн боловч арбитрын үндсэн шийдвэрт тусгаагүй орхисон нэхэмжлэлийн шаардлагын талаар нэмэлт шийдвэр гаргахыг үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шаардаж болно. Арбитрын бүрэлдэхүүн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл 60 хоногийн дотор нэмэлт шийдвэр гаргана.

46.6.Арбитрын бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 46.1, 46.2, 46.5-д заасан засвар оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах хугацааг сунгахаар шийдвэрлэж болно.

46.7.Арбитрын үндсэн шийдвэрт засвар оруулах, тайлбар хийх, нэмэлт шийдвэр гаргахад энэ хуулийн 44 дүгээр зүйл нэг адил хамаарна.

ДОЛДУГААР БҮЛЭГ АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРИЙН ТАЛААР ӨРГӨДӨЛ ГАРГАХ

47 дугаар зүйл.Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох тухай өргөдөл гаргах

47.1.Талууд арбитрын үндсэн шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 47.2, 47.3-т заасан үндэслэл, журмын дагуу арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлөө шүүхэд гаргана.

47.2.Энэ хуулийн 47.5-д заасан шүүх нь арбитрын үндсэн шийдвэрийг зөвхөн дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:

47.2.1.өргөдөл гаргагч тал дараахь аль нэг нөхцөл байдлыг нотолсон:

47.2.1.а.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тийнхүү тохиролцон сонгоогүй бол Монгол Улсын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус;

47.2.1.б.өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцох боломжгүй байсан;

47.2.1.в.арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан. Хэрэв нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан арбитрын үндсэн шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүчингүй болгоно;

47.2.1.г.талуудын тохиролцоо нь энэ хуулийн заавал дагаж мөрдөх заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын тохиролцоонд нийцээгүй,

эсхүл тийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа нь энэ хуульд нийцээгүй.

47.2.2.шүүх дараахь нөхцөл, байдлыг тогтоосон бол:

47.2.2.а.Монгол Улсын хуулиар уг маргаан арбитрын харьяаллын маргаан биш;

47.2.2.б.арбитрын үндсэн шийдвэр Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн.

47.3.Талууд арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш, эсхүл энэ хуулийн 46 дугаар зүйлийн дагуу гаргасан хүсэлтийг шийдвэрлэснээс хойш дотоодын арбитрын ажиллагааны хувьд 30 хоногийн дотор, олон улсын арбитрын ажиллагааны хувьд 90 хоногийн дотор энэ хуулийн 47.1-д заасан өргөдлийг шүүхэд гаргана.

47.4.Аль нэг тал хүсэлт гаргасан бөгөөд арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдөл хүлээн авсан шүүх боломжтой гэж үзсэн бол арбитрын ажиллагааг сэргээж, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлийг арилгах боломжийг арбитрын бүрэлдэхүүнд олгох зорилгоор арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай өргөдлийг хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой хугацаа тогтоон түдгэлзүүлж болно.

47.5.Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг энэ хуулийн 6.2-т заасан шүүхэд гаргах бөгөөд уг өргөдлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ АРБИТРЫН ҮНДСЭН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, ГҮЙЦЭТГЭХ

48 дугаар зүйл.Үндсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх

48.1.Аль улсад гаргаснаас үл хамааран арбитрын үндсэн шийдвэрийг заавал биелүүлэх хүчинтэй гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд харьяалах шүүхэд бичгээр өргөдөл гаргаснаар энэ хуулийн 48, 49 дүгээр зүйл болон Гадаадын арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай 1958 оны Нью Йоркийн конвенцид заасан журмын дагуу арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгэнэ.

48.2.Арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр өргөдөл гаргаж байгаа тал уг шийдвэрийн эх хувь, эсхүл зохих ёсоор баталгаажуулсан

хуулбарыг хавсарган өгнө. Арбитрын үндсэн шийдвэрийг монгол хэлээр гаргаагүй бол монгол хэлээр орчуулсан хувийг гаргаж өгөхийг тухайн талаас шаардаж болно.

49 дүгээр зүйл.Арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах үндэслэл

49.1.Аль улсад гаргаснаас үл хамааран арбитрын үндсэн шийдвэрийг үл хүлээн зөвшөөрч, гүйцэтгэхээс доор дурдсан үндэслэлээр татгалзаж болно:

49.1.1.арбитрын үндсэн шийдвэрээр үүрэг хүлээсэн тал уг шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай өргөдлийг хүлээн авсан шүүхэд дараахь нөхцөл байдлын аль нэгийг нотолсон:

49.1.1.а.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тохиролцон сонгоогүй бол хуульд зааснаар хүчин төгөлдөр бус;

49.1.1.б.арбитрын үндсэн шийдвэрээр үүрэг хүлээсэн талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцож тайлбар өгөх боломжгүй байсан;

49.1.1.в.арбитрын бүрэлдэхүүн үндсэн шийдвэрээ нэхэмжлэлд дурдаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан. Арбитрт гаргасан нэхэмжлэлд дурдаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан үндсэн шийдвэрийн заалтыг нэхэмжлэлд дурдсан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэж болно;

49.1.1.г.арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын хэлэлцээрт нийцээгүй, эсхүл тийм хэлэлцээр байгуулаагүй бол арбитрын ажиллагаа харьяалагдах улсын хуульд нийцээгүй;

49.1.1.д.тухайн үндсэн шийдвэр хүчин төгөлдөр болоогүй байгаа, эсхүл шийдвэр гаргасан улсын шүүхээс, эсхүл уг шийдвэрт хэрэглэгдэх улсын хуулийн дагуу шийдвэр хүчингүй болсон, үндсэн шийдвэрийн гүйцэтгэлийг түдгэлзүүлсэн;

49.1.2.шүүх дараахь байдлыг тогтоосон:



49.1.2.а.Монгол Улсын хуулиар уг маргаан арбитрын харьяаллын маргаан биш;

49.1.2.б.арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх нь Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн.

49.2.Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох, эсхүл түдгэлзүүлэх тухай өргөдлийг энэ хуулийн 49.1.1.д-д заасан шүүхэд гаргасан бөгөөд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх тухай өргөдөл хүлээн авсан шүүх зохимжтой гэж үзсэн бол шүүх хуралдааныг хойшлуулж, өргөдөл гаргагч талын хүсэлтээр зохих санхүүгийн баталгаа гаргах үүргийг нөгөө талд хүлээлгэж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

50 дугаар зүйл.Нууцлал

50.1.Талууд өөрөөр тохиролцоогүй бол доор дурдсанаас бусад тохиолдолд арбитрын шийдвэр, тогтоол, арбитрын ажиллагааны явцад талуудаас ирүүлсэн мэдээллийн нууцлалыг талууд, арбитрын бүрэлдэхүүн, байнгын арбитр хадгалах үүрэгтэй:

50.1.1.тухайн тал нь мэдээллийг ил тод болгох үүргийг хуулиар хүлээсэн;

50.1.2.хууль ёсны эрхээ хамгаалах, хэрэгжүүлэхэд шаардлагатай болсон;

50.1.3.арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох, гүйцэтгүүлэхээр шүүхэд өргөдөл гаргасан.

51 дүгээр зүйл.Дампуурал

51.1.Арбитрын хэлэлцээр бүхий гэрээний аль нэг талтай холбоотой дампуурлын хэрэг үүссэн бөгөөд хэрэг гүйцэтгэгч, эрх хүлээн авагч уг гэрээнээс татгалзаагүй бол арбитрын хэлэлцээр нь тухайн этгээдийн хувьд хүчин төгөлдөр байна.

51.2.Дампуурлын хэргийг үүсгэсэн шүүх дараахь бүх нөхцөл бүрдсэн бөгөөд тухайн нөхцөл байдалд зохимжтой гэж үзвэл дампуурлын ажиллагаатай холбоотой маргааныг шийдвэрлүүлэхээр арбитрт шилжүүлж болно:

51.2.1. тухайн маргаан нь арбитрын хэлэлцээрт хамаарч байгаа;

51.2.2. дампуурлын хэргийн хариуцагч нь дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө арбитрын хэлэлцээр байгуулсан;

51.2.3. хэрэг гүйцэтгэгч, эрх хүлээн авагч нь арбитрын хэлэлцээрийг агуулсан гэрээнээс татгалзаагүй.

52 дугаар зүйл. Бусад

52.1. Энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах харилцааг шууд тусгайлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол энэ хуулийн үндсэн зарчимд нийцүүлэн зохицуулна.

52.2. Энэ хуулийн 37.1.1, 45.2.1-д зааснаас бусад тохиолдолд нэхэмжлэл, түүний хариу тайлбарт холбогдох заалт нь сөрөг нэхэмжлэл, түүний хариу тайлбарт нэгэн адил хамаарна.

52.3. Энэ хуулийн 40 дүгээр зүйлээс бусад зүйлд талууд тодорхой асуудлыг тодорхойлох эрхтэй байхаар заасан нь арбитрыг оролцуулан гуравдагч этгээдэд уг асуудлыг тодорхойлох эрхээ шилжүүлэх талуудын эрхэд нэгэн адил хамаарна.

52.4. Талууд тохиролцсон, эсхүл тохиролцоо байж болох тухай үйл баримтыг, эсхүл бусад тохиролцоог энэ хуульд аливаа байдлаар дурдсан бол тохиролцоонд дурдсан арбитрын дүрмийг тухайн тохиролцоотой адилтган үзнэ. Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө, эсхүл эхэлсний дараа талуудын тохиролцон зөвшөөрсөн, эсхүл сонгосон арбитрын дүрмийн заалт нь энэ хуулийн заавал мөрдвөл зохих заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

АРБИТРЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 5 дугаар сарын 09-ний өдөр баталсан Арбитрын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай Арван дөрөвдүгээр¹ бүлэг нэмсүгэй:

“АРВАН ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ АРБИТРЫН АЖИЛЛАГААНД ШҮҮХ ОРОЛЦОХ

160¹ дүгээр зүйл.Арбитрын ажиллагаанд шүүх оролцох

160¹.1.Арбитрын хэлэлцээрийн аль нэг тал, эсхүл арбитр нь энэ хуулийн 160²-т зааснаас бусад Арбитрын тухай хуульд заасан өргөдөл, хүсэлтээ мөн хуульд заасан харьяаллын шүүхэд ирүүлнэ.

160¹.2.Энэ хуулийн 160¹.1-д заасан өргөдөл, хүсэлтэд арбитрын хэлэлцээрийн талуудын нэр, хаяг, арбитрын ажиллагааны харьяалал, маргаан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа буюу явуулсан арбитр, нэхэмжлэлийн шаардлага, шүүхийн шийдвэрээр хэрэгжүүлэхийг хүсч байгаа ажиллагааг явуулах үндэслэл, шаардлагын талаар тусгана.

160¹.3.Шүүх хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэр гаргах бөгөөд шүүх шийдвэртээ хүсэлтийг хангасан болон хангахаас татгалзсан үндэслэлийг заана.

160² дугаар зүйл.Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдөл

160².1.Арбитрын хэлэлцээрийн тал нь Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан үндэслэлээр арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлөө Арбитрын тухай хуульд заасан харьяаллын шүүхэд гаргаж болно.



160².2.Энэ хуулийн 160².1-д заасан өргөдөл гаргагч нь хуульд заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж төлнө.

160².3.Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг бичгээр үйлдэж, өргөдөл гаргагч буюу түүний хууль ёсны төлөөлөгч гарын үсэг зурна.

160².4.Өргөдөлд дараахь зүйлийг тусгана:

160².4.1.гарчиг;

160².4.2.үндсэн шийдвэр гаргасан арбитрч, арбитрын бүрэлдэхүүний нэр;

160².4.3.арбитрын ажиллагаанд оролцогч талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ хаяг, утас, факсын дугаар, цахим шуудангийн хаяг;

160².4.4.арбитрын үндсэн шийдвэр гарсан огноо, газар;

160².4.5.өргөдөл гаргагч арбитрын үндсэн шийдвэрийг хүлээн авсан огноо;

160².4.6.арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах үндэслэл.

160².5.Энэ хуулийн 160².4-т заасан өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

160².5.1.арбитрын үндсэн шийдвэрийн эх хувь буюу түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар, хэрэв үндсэн шийдвэр гадаад хэлээр бичигдсэн бол түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулга;

160².5.2.арбитрын хэлэлцээрийн эх хувь буюу түүний нотариатаар баталгаажуулсан хуулбар, хэрэв хэлэлцээр гадаад хэлээр бичигдсэн бол түүний монгол хэл дээрх албан ёсны орчуулга;

160².5.3.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

160².5.4.арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах үндэслэлээ нотлох баримт;

160².5.5.арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдөлд гарын үсэг зурсан этгээдийн бүрэн эрхийг нотолсон баримт бичиг буюу итгэмжлэл.



160².6.Шүүх энэ зүйлд заасан журмыг зөрчиж гаргасан өргөдлийг буцааж, уг зөрчлийн талаар мэдэгдэнэ.

160³ дугаар зүйл.Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг хянан хэлэлцэх журам

160³.1.Шүүх арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг хүлээж авснаас хойш энэ хуульд заасан журмын дагуу 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

160³.2.Шүүх арбитрын хэлэлцээрийн талуудын хүсэлтээр арбитрын хэргийг энэ хуульд заасан журмаар гаргуулан авч болно.

160³.3.Шүүх хуралдаан болох огноо, цаг, газрыг арбитрын маргаанд оролцогч талуудад мэдэгдэнэ. Уг мэдэгдлийг хүлээн авсан этгээд шүүх хуралдаанд ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

160³.4.Шүүх Арбитрын тухай хуулийн 47.2-т заасан арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл байгаа эсэхийг талуудын өргөдлийн шаардлага болон татгалзлаа үндэслэж байгаа, шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтыг шинжлэх замаар тогтооно.

160⁴ дүгээр зүйл.Арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийг хэлэлцсэн тухай шүүхийн тогтоол

160⁴.1.Шүүх арбитрын үндсэн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай маргааныг хянан хэлэлцэж арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгох тухай тогтоол гаргана.

160⁴.2.Энэ хуулийн 160⁴.1-д заасан тогтоолд хуульд зааснаас гадна доор дурдсан зүйлийг тусгана:

160⁴.2.1.маргаж байгаа шийдвэрийн тухай мэдээлэл, түүнийг гаргасан газар;

160⁴.2.2.маргаж байгаа шийдвэрийг гаргасан арбитрч буюу арбитрын бүрэлдэхүүн;

160⁴.2.3.арбитрын хэлэлцээрийн талуудын нэр;

160⁴.2.4.арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай өргөдлийн агуулга;



160⁴.2.5.шүүхээс гаргаж байгаа шийдвэрийн үндэслэл;

160⁴.2.6.арбитрын үндсэн шийдвэрийг хэвээр үлдээсэн, эсхүл бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгосон тухай заалт.

160⁴.3.Энэ зүйлд заасан тогтоол эцсийн шийдвэр байна.

160⁵ дугаар зүйл.Шүүхийн ажиллагааг хаалттай явуулах

160⁵.1.Арбитрын ажиллагааны аль нэг тал энэ бүлэгт заасан өргөдөл, хүсэлтийг хянан хэлэлцэх шүүхийн ажиллагааг хаалттай явуулах тухай хүсэлт гаргасныг Монгол Улсын нийтлэг ашиг сонирхолд харшлахгүй гэж шүүх үзсэн бол уг ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаалттай явуулахаар шийдвэрлэж болно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Газрын тосны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “гомдлоо” гэсний дараа “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалтын “маргааныг” гэсний дараа “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “маргааныг” гэсний дараа “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Концессын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “хуульд заасан аргаар болон” гэснийг “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн “маргааныг” гэсний дараа “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ
ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “маргааныг” гэсний дараа “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн “маргааныг” гэсний дараа “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Валютын зохицуулалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “маргааныг” гэсний дараа “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ВЕКСЕЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Векселийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “шүүх” гэсний дараа “, арбитр” гэж, 2 дахь хэсгийн “маргааныг” гэсний дараа “шүүх, арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийн “өмчлөгч” гэсний дараа “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж, 193 дугаар зүйлийн 193.2 дахь хэсгийн “шүүхээр” гэсний өмнө “арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Иргэний хуулийн 42¹ дүгээр зүйлийн 42^{1.2} дахь хэсгийн “Цахим хэлбэрээр” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр” гэж, 211 дүгээр зүйлийн 211.1 дэх хэсгийн “шүүхийн” гэснийг “шүүх, арбитрын” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 253 дугаар зүйлийн 253.1 дэх хэсэгт “оролцогчид” гэсний дараа “, арбитрын ажиллагааны талууд,” гэж, “шүүгч” гэсний дараа “, арбитрч” гэж, 254 дүгээр зүйлийн 254.1 дэх хэсгийн “болон” гэсний дараа “ арбитр,” гэж, 265 дугаар зүйлийн 265.1 дэх хэсгийн “албан тушаалтан” гэсний дараа “, арбитрч” гэж, 266 дугаар зүйлийн 266.1 дэх хэсгийн “албан тушаалтан” гэсний дараа “, арбитрч” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 35 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“35 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

35.1. Арбитрын хэлэлцээртэй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

35.2. Энэ хуулийн 35.1-д зааснаас бусад тохиолдолд Зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь өөрийн эрх мэдэлд



хамаарах асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэнэ.

35.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь энэ хуулийн 35.2-т заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“22 дугаар зүйл.Маргаан шийдвэрлэх

22.1.Арбитрын хэлэлцээртэй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

22.2.Энэ хуулийн 22.1-д зааснаас бусад тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон хангагч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг Зохицуулах зөвлөл шийдвэрлэнэ.

22.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь энэ хуулийн 22.2-т заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс



зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12 дахь заалтын “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэсний өмнө “тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Харилцаа холбооны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“31 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэх

31.1.Арбитрын хэлэлцээртэй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

31.2.Энэ хуулийн 31.1-д зааснаас бусад тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг Зохицуулах хороо, салбар зөвлөл шийдвэрлэнэ.

31.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь энэ хуулийн 31.2-т заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.”



3 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 88¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“88¹ дүгээр зүйл.Маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх

88^{1.1}.Арбитрын хэлэлцээртэй бол зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, харилцагчийн хооронд гарсан маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

88^{1.2}.Энэ хуулийн 88^{1.1}-д заасны дагуу маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх тохиолдолд энэ хуулийн 88 дугаар зүйл хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай 82¹ дүгээр зүйл нэмсүгэй:



“82¹ дүгээр зүйл.Маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх

82¹.1.Арбитрын хэлэлцээртэй бол даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

82¹.2.Энэ хуулийн 82¹.1-д заасны дагуу маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх тохиолдолд энэ хуулийн 82 дугаар зүйл хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 01 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 44¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“44¹ дүгээр зүйл.Маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх

44¹.1.Арбитрын хэлэлцээртэй бол даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

44¹.2.Энэ хуулийн 44¹.1-д заасны дагуу маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх тохиолдолд энэ хуулийн 44 дүгээр зүйл хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арбитрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж

2.1.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулан зохицуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.



4.1.2.“аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг;

4.1.3.“осол” гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;

4.1.4.“гамшгийн эрсдэл” гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг;

4.1.5.“аюул” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг;

4.1.6.“эмзэг байдал” гэж аюулд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөгдөх зэргийг;

4.1.7.“гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг;

4.1.8.“гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа” гэж гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг;

4.1.9.“гамшгийн зарлан мэдээлэл” гэж олон нийтэд хүргэх дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг;

4.1.10.“эрэн хайх, аврах ажиллагаа” гэж голомтын бүсэд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг;

4.1.11.“голомтын бүс” гэж гамшиг, аюулт үзэгдэл болон ослын улмаас хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг;

4.1.12.“нэрвэгдэгсэд” гэж гамшиг болон аюулд өртсөн иргэдийг;



4.1.13. “гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах” гэж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэмэлт хүч хэрэгслийг татан оролцуулах, шаардлагатай барилга байгууламж, газрыг ашиглахыг;

4.1.14. “гамшгийн хор уршиг” гэж гамшгийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, хүрээлэн байгаа орчинд нөлөөлсөн сөрөг үр дагаврыг;

4.1.15. “гамшгийн хор уршгийг арилгах” гэж энэ хуулийн 4.1.14-д заасан үр дагаврыг багасгах, хоёрдогч аюулын шинж чанарыг бууруулах, гамшгийг гэтлэн давахад чиглэсэн хойшлуулшгүй үйл ажиллагааг;

4.1.16. “хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа” гэж гамшгийн улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээг;

4.1.17. “мэргэжлийн анги” гэж сум, дүүрэг, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдсан, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг;

4.1.18. “сайн дурын хэсэг” гэж сайн дурын үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохоор зохих сургалтад хамрагдсан иргэдийг.

5 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчим

5.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

5.1.1. хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай байх;

5.1.2. мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх;

5.1.3. шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурласан байх;

5.1.4. өмчийн хэлбэрийг үл харгалзах;

5.1.5. иргэдийн оролцоонд тулгуурлах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГАМШГИЙН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6 дугаар зүйл. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа

6.1. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь дараахь төрөлтэй байна:

- 6.1.1. гамшгийн эрсдэлийг үнэлэх;
- 6.1.2. гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;
- 6.1.3. гамшгийн эрсдэлийг бууруулах;
- 6.1.4. гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;
- 6.1.5. гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;
- 6.1.6. гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах;
- 6.1.7. гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх.

7 дугаар зүйл. Гамшгийн эрсдэлийг үнэлэх

7.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.

7.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг энэ хуулийн 7.3-т заасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.

7.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь шаардлагыг хангасан хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоно:

7.3.1. эрсдэлийн үнэлгээний шинжээчийн бүрэлдэхүүн нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх;

7.3.2. шаардлагатай судалгаа, шинжилгээний багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

7.3.3. гамшгийн эрсдэлийн үнэлгээнд шаардагдах мэдээ, баримт, өгөгдөл бүхий мэдээллийн сантай байх;

7.3.4. гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх тогтсон арга, аргачлалтай байх.

7.4. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.

7.5. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гамшгийн эрсдэлийн үнэлгээний гүйцэтгэл, тайланд хяналт тавьж ажиллана.

7.6.Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг энэ хуулийн 7.1-д заасан байгууллага өөрөө хариуцна.

8 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх

8.1.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна.

8.2.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.

8.3.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9 дүгээр зүйл.Гамшгийн эрсдэлийг бууруулах

9.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор энэ хуулийн 8.1-д заасан байгууллага, хуулийн этгээд дараахь арга хэмжээг авна:

9.1.1.болзошгүй гамшгийн шалтгаан, нөхцөлийг арилгах;

9.1.2.барилга байгууламж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг улс, орон нутгийн төсөвт байгууллага, үйлдвэр, үйлчилгээний байгууллагын аюулгүй байдлын шаардлага, стандартыг хангах;

9.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх;

9.1.4.гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх;

9.1.5.хөгжлийн бодлогын төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох.

9.2.“Бүтцийн арга хэмжээ” гэж барилга байгууламж, объект, зам, гүүр зэрэг дэд бүтэц, биет зүйлийн аюулгүй болон гамшигт тэсвэртэй байдлыг хангах арга хэмжээг ойлгоно.

9.3.“Бүтцийн бус арга хэмжээ” гэж хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөх, гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах болон бусад арга хэмжээг ойлгоно.



10 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах

10.1.Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах бэлэн байдлын дараахь зэрэгтэй байна:

- 10.1.1.өдөр тутмын бэлэн байдал;
- 10.1.2.өндөржүүлсэн бэлэн байдал;
- 10.1.3.бүх нийтийн бэлэн байдал.

10.2.Гамшгийн бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

10.3.Өдөр тутмын бэлэн байдлын үед дараахь арга хэмжээг авна:

10.3.1.нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах;

10.3.2.харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд хүн амыг сургаж дадлагажуулах;

10.3.3.гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

10.3.4.гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх;

10.3.5.гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэх;

10.3.6.гамшгийн үед дайчлан гаргах хүч хэрэгслийн бүртгэл, тооцоог гаргах.

10.4.Тодорхой нутаг дэвсгэр, объектод гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж дараахь арга хэмжээг авна:

10.4.1.гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжүүлэх;

10.4.2.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх;

10.4.3.гамшгийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх;

10.4.4.хорио цээрийн дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах;

10.4.5.гамшгийн нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх.

10.5.Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна.

10.6.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжид үүссэн голомтын бүсэд эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж дараахь арга хэмжээг авна:

10.6.1.харилцаа холбоо, эрчим хүч, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад үйлдвэр, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах;

10.6.2.гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

10.7.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед энэ хуулийн 10.4.1-10.4.5-д заасан арга хэмжээг нэгэн адил хэрэгжүүлнэ.

10.8.Энэ хуулийн 10.4.2-т заасан ажлын тусгай горимоор ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

11 дүгээр зүйл.Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх

11.1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шат дараатай зохион байгуулах, хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 11.3-т заасан албан тушаалтан холбогдох шийдвэрийн дагуу өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлнэ.



11.2.Бэлэн байдлын зэрэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар, шат дараалан, эсхүл шууд шилжүүлнэ.

11.3.Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэрийг дараахь албан тушаалтан гаргана:

11.3.1.сум, дүүргийн нутаг дэвсгэрт, эсхүл түүний зарим хэсэгт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн сум, дүүргийн Засаг дарга;

11.3.2.хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед холбогдох мэргэжлийн байгууллага болон тухайн сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга;

11.3.3.улсын хэмжээнд, эсхүл аймаг, нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар;

11.3.4.шаардлагатай тохиолдолд эрхэлсэн салбарыг гамшгаас хамгаалах улсын албаны дарга.

11.4.Энэ хуулийн 11.3-т заасан албан тушаалтны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх саналд нутаг дэвсгэрээр дамжин тархсан, бүс нутгийг хамарсан, хамарч болзошгүй гамшгийн цагийн байдлын үнэлгээ, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэлийг тусгаж шийдвэрийн төслийг хавсаргана.

11.5.Гамшгаас хамгаалах сургалтын үед тухайн шатны Засаг даргын шийдвэрээр өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт түр шилжүүлж болно.

11.6.Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргасан албан тушаалтан, эсхүл түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан бэлэн байдлын зэргийг бууруулах, цуцлах шийдвэрийг гаргана.

12 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх

12.1.Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавина.



12.2.Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг Засгийн газар батална.

12.3.Гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагч нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга байна.

13 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах

13.1.Гамшгаас хамгаалах сургалт нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтан болон иргэнийг сургаж дадлагажуулахад чиглэнэ.

13.2.Гамшгаас хамгаалах сургалтыг дараахь ангиллаар явуулна:

13.2.1.удирдах албан тушаалтны;

13.2.2.онцгой байдлын байгууллагын;

13.2.3.оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн;

13.2.4.төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны;

13.2.5.гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн;

13.2.6.иргэний.

13.3.Гамшгаас хамгаалах сургалтыг дараахь байгууллага, албан тушаалтан зохион байгуулна:

13.3.1.онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтан, гамшгаас хамгаалах улсын алба, аймаг, нийслэлийн удирдах албан тушаалтны сургалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

13.3.2.орон нутгийн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн удирдах албан тушаалтан, цэргийн албыг биеэр дүйцүүлэн алба хааж байгаа иргэний сургалтыг орон нутгийн онцгой байдлын байгууллага;

13.3.3.сум, дүүргийн мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтыг тухайн шатны Засаг дарга;



13.3.4.иргэний сургалтыг тухайн баг, хорооны Засаг дарга;
13.3.5.онцгой байдлын байгууллагын алба хаагчийн сургалтыг тухайн нэгжийн дарга;

13.3.6.оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн сургалтыг батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу тухайн шатны боловсролын байгууллага;

13.3.7.хуулийн этгээдийн ажилтны сургалтыг тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан.

13.4.Энэ зүйлийн 13.3.1-д заасан сургалтыг 2 жилд нэг удаа, 13.3.2, 13.3.3, 13.3.4, 13.3.5, 13.3.7-д заасан сургалтыг жил бүр зохион байгуулна.

13.5.Энэ хуулийн 13.2-д заасан сургалтыг зохион байгуулахад Монголын улаан загалмай нийгэмлэг эрхлэх асуудлынхаа хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

14 дүгээр зүйл.Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх

14.1.Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ хийх, үр дүн, санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа ашиглах, мэдээлэх, нийтийн хүртээл болгох, гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

14.2.Гамшгийн мэдээллийн сан дараахь мэдээллээс бүрдэнэ:

14.2.1.гамшгийн эрсдэлтэй нутаг дэвсгэрийн газар зүйн мэдээлэл;

14.2.2.гамшигт нэрвэгдэж болзошгүй хүн ам, дэд бүтцийн бүртгэл, мэдээлэл;

14.2.3.гамшиг, аюулт үзэгдэл, ослын болон хохирлын дүн мэдээ;

14.2.4.бусад мэдээлэл.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАМШГИЙН ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

15 дугаар зүйл. Гамшгийн үеийн үйл ажиллагаа

15.1. Гамшгийн үеийн үйл ажиллагаа дараахь арга хэмжээнээс бүрдэнэ:

15.1.1. гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах;

15.1.2. голомтын бүсийг тогтоох;

15.1.3. эрэн хайх, аврах;

15.1.4. хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх;

15.1.5. гамшгийн хор уршгийг арилгах.

15.2. Гамшгийн үеийн үйл ажиллагааг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулна.

15.3. Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

16 дугаар зүйл. Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах

16.1. Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулна.

16.2. Гамшиг болон аюулын тухай мэдээ, мэдээллийг цуглуулах, холбогдох шийдвэрийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хүргэх, түүнчлэн улс хооронд харилцан мэдээлэл солилцоход харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг ашиглана.

16.3. Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй.

16.4. Голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй холбоо зохион байгуулах, мэдээлэл солилцох ажиллагааг онцгой байдлын байгууллага гүйцэтгэнэ.

16.5. Гамшгийн зарлан мэдээлэл, түүнийг дамжуулах журмыг Засгийн газар батална.

17 дугаар зүйл.Голомтын бүс тогтоох

17.1.Голомтын бүсийг доор дурдсан албан тушаалтан тогтооно:

17.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга;

17.1.2.хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэр болон улсын онц чухал объектод онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар.

18 дугаар зүйл.Эрэн хайх, аврах

18.1.Эрэн хайх, аврах ажиллагааг томилгоот шуурхай бүлэг гүйцэтгэнэ.

18.2.Шуурхай бүлгийн удирдагч онцгой байдлын байгууллагын алба хаагч байх ба эрэн хайх, аврах ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй.

18.3.Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож байгаа сайн дурын хэсэг, иргэн шуурхай бүлгийн удирдагчийн зааврын дагуу үүрэг гүйцэтгэнэ.

18.4.Нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг эмнэлгийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай үзүүлэх үүрэгтэй.

18.5.Энэ хуулийн 18.1-т заасан томилгоот шуурхай бүлгийн ажиллах журам, зааврыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

19 дүгээр зүйл.Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх

19.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ.

19.2.Энэ хуулийн 24.1-д заасан хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журмыг Засгийн газар батална.

20 дугаар зүйл.Гамшгийн хор уршгийг арилгах

20.1.Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өөрөө, эсхүл үүссэн



нөхцөл байдлыг харгалзан онцгой байдлын байгууллага мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд шаардлагатай тохиолдолд үүссэн хохирол, хэрэгцээнд тулгуурлан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

20.3.Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.

20.4.Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох, нэрвэгдэгсдэд дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА

21 дүгээр зүйл.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа

21.1.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа дараахь чиглэлтэй байна:

- 21.1.1.нийгмийн амьдралыг хэвийн нөхцөлд оруулах;
- 21.1.2.дэд бүтцийг сэргээн босгох.

21.2.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардлыг улсын хэмжээнд Засгийн газар, орон нутгийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

21.3.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг авч болно.

ТАВДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА

22 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт

22.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна.



22.2.Улсын хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд орон нутгийн зөвлөл /цаашид “Үндэсний болон орон нутгийн зөвлөл” гэх/-ийг байгуулна.

22.3.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хяналт тавих зорилгоор Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.

22.4.Онцгой байдлын байгууллага нь улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулна.

22.5.Үндэсний болон орон нутгийн зөвлөл нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэгтэй бөгөөд орон тооны бус байна.

22.6.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус улсын албыг Засгийн газар, аймаг, нийслэл, дүүрэгт орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна.

22.7.Сум, баг, хороонд нутгийн иргэдэд түшиглэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулж болно.

22.8.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хуулийн этгээд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангитай байна.

22.9.Үндэсний зөвлөл, Улсын онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын албаны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар, мэргэжлийн ангийн ажиллах дүрмийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага

23.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид

тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

23.2.Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд, орон нутгийн зөвлөлийг тухайн шатны Засаг дарга тэргүүлнэ.

23.3.Улсын онцгой комиссыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга тэргүүлнэ.

23.4.Улсын онцгой комиссын орлогч дарга нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн онцгой комиссын орлогч дарга нь орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга, сумын онцгой комиссын орлогч дарга нь тухайн сумын Засаг даргын Тамгын газрын дарга байна.

24 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл

24.1.Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, техник хэрэгсэл, эрэлч нохой, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа болон цэргийн жинхэнэ алба хаасан иргэн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хуулийн этгээд, түүний техник хэрэгсэл байна.

24.2.Мэргэжлийн ангийг Монгол Улсын харьяат, хөдөлмөрийн чадвартай, 18-60 хүртэлх насны эрэгтэй, 18-55 хүртэлх насны эмэгтэй иргэнээр бүрдүүлэх бөгөөд цэргийн жинхэнэ алба хаагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэй, өрх толгойлсон эх /эцэг/ хамаарахгүй.

24.3.Монголын улаан загалмай нийгэмлэг нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт хүч болон ажиллана.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДЛАГЫН БҮРЭН ЭРХ

25 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

25.1.Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гамшиг тохиолдсон үед Монгол Улсын Их Хурал уг асуудлыг дараалал харгалзахгүйгээр хэлэлцэнэ.

25.2.Монгол Улсын Их Хурал гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсийг тодорхойлно.

26 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

26.1. Монгол Улсын Засгийн газар гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1. Монгол Улсын гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үндэсний төсөл, хөтөлбөрийг батлах;

26.1.2. Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэл тогтоох журмыг батлах;

26.1.3. гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг оролцуулах шийдвэрийг зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр гаргах;

26.1.4. олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд аврах багийг оролцуулах шийдвэр гаргах;

26.1.5. аюулын түвшин, нөхцөл байдлын талаар нийтэд зарлан мэдээлэх.

27 дугаар зүйл. Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэн эрх

27.1. Үндэсний зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тогтвортой хөгжлийн бодлого, хөтөлбөрт гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн зорилт болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулах талаар бодлогын зөвлөмж өгөх;

27.1.2. гамшгийн дараахь сэргээн босгох арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх, улс орны тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод уялдуулах бодлогын зөвлөмж гаргах;

27.1.3. гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах;

27.1.4. гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник, технологийн шинэ ололт, инновацийг нэвтрүүлэх талаар чиглэл өгөх;

27.1.5.орон нутгийн зөвлөлийг бодлого, зөвлөмжөөр хангах.

27.2.Орон нутгийн зөвлөл энэ хуулийн 27.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

28 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

28.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан чиглүүлэх;

28.1.2.улсын хэмжээнд, эсхүл аймаг, нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;

28.1.3.гамшгийн нөөцийг зохих журмын дагуу захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэлтэд хяналт тавих;

28.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс, бараа, материал, тоног төхөөрөмжийг улсын нөөцөөс гаргах асуудлыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;

28.1.5.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавар, удирдамжийг батлах;

28.1.6.гамшгийн нөхцөл байдлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад шуурхай мэдээлэх;

28.1.7.олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд аврах багийг оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;

28.1.8.гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг татан оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;

28.1.9.онцгой байдлын байгууллагыг хөгжүүлэх бодлого болон түүний үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлэх



арга хэмжээний санал боловсруулан Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх;

28.1.10.барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх.

29 дүгээр зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

29.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь чиг үүрэгтэй:

29.1.1.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах, хяналт тавих;

29.1.2.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

29.1.3.өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх удирдамжийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх;

29.1.4.орон нутгийн онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хяналт тавих;

29.1.5.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах;

29.1.6.шаардлагатай мэдээлэл, судалгааг гаргаж, гамшгийн цагийн байдлыг нэгтгэн дүгнэж онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах;

29.1.7.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хүч хэрэгслийг дайчлан оролцуулах;

29.1.8.гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэхэд гарсан зардал, нөхөн төлбөрийн талаар санал боловсруулан хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх;

29.1.9.Засгийн газраас олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай



газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

29.1.10.гамшгаас хамгаалах алба, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх;

29.1.11.гамшгийн нөөц бүрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, нөхөн сэлбэх;

29.1.12.гамшгийн мэдээллийн сан байгуулах, ашиглах;

29.1.13.гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, заавар, стандарт боловсруулах;

29.1.14.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

29.1.15.гамшгаас хамгаалах талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

29.1.16.гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох саналыг эрх бүхий байгууллагад танилцуулах;

29.1.17.гамшгаас хамгаалах асуудлаар гадаад улс, олон улсын болон дотоодын байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

29.1.18.олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох багийг бүрдүүлж, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

29.1.19.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүн амыг сургах, бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

30 дугаар зүйл.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх

30.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1.гамшгаас хамгаалах албаны гүйцэтгэх үүргийг тодорхойлж, мэргэжлийн удирдлагаар хангах;



30.1.2.голомтын бүсэд эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах хүч хэрэгслийг дайчлан оролцуулах;

30.1.3.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүн амыг сургах, бэлтгэх үйл ажиллагааг чиглүүлэх;

30.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон онцгой байдлын байгууллагад дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, стандартыг баталж мөрдүүлэх;

30.1.5.гамшгаас хамгаалах бэлэн байдлын удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих;

30.1.6.гамшиг болон аюулын нөхцөл байдлын талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд шуурхай мэдээлэх;

30.1.7.гамшгаас хамгаалах харилцан ажиллагааны төлөвлөгөөг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран батлах;

30.1.8.онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах;

30.1.9.барилга байгууламж, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хангамжийн талаархи бодлогыг боловсруулж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах, шийдвэрлүүлэх;

30.1.10.хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах;

30.1.11.онцгой байдлын байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах;

30.1.12.онцгой байдлын байгууллагыг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, цуцлах шийдвэр гаргах;

30.1.13.онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

30.1.14.онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын газар, хэлтэс, харьяа нэгжийн алба хаагч болон бусад ажилтныг томилох, чөлөөлөх;



30.1.15.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу цэргийн цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх, сахилга, ёс зүйн хариуцлага хүлээлгэх;

30.1.16.төсөв, хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах;

30.1.17.үүссэн цагийн байдалтай холбогдуулан шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг татан оролцуулах саналыг зэвсэгт хүчний ерөнхий командлагчид шууд танилцуулан шийдвэрлүүлэх.

30.2.Орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга энэ хуулийн 30.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

30.3.Орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.

31 дүгээр зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

31.1.Нутгийн өөрөө удирдах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1.аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг баталж, гүйцэтгэлд хяналт тавих;

31.1.2.гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи Засаг даргын мэдээллийг сонсох, тайланг хэлэлцэх, чиглэл өгөх;

31.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг санхүүжүүлэх сан байгуулах шийдвэр гаргах.

32 дугаар зүйл.Засаг даргын бүрэн эрх

32.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гамшгаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх;



32.1.2. нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох;

32.1.3. гамшиг болон аюулын үед шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах;

32.1.4. гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны болон онцгой байдлын байгууллагад мэдээлэх, мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, дэмжлэг авах;

32.1.5. хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу хүмүүнлэгийн тусламжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хуваарилах ажлыг зохион байгуулах, тайлагнах;

32.1.6. нэрвэгдэгсдэд санхүүгийн болон эд материал, сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

32.1.7. гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах;

32.1.8. гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

32.1.9. гамшиг болон аюулын үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулах;

32.1.10. орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх;

32.1.11. харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах;

32.1.12. гамшгийн эрсдэлийн болон гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

32.1.13. тухайн шатны Засаг дарга нь төв, орон нутаг томилогдон ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтныг албан тушаалын орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх.

32.2. Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 32.1-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

33 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг

33.1.Гамшгаас хамгаалах улсын алба дараахь чиг үүрэгтэй:

33.1.1.салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

33.1.2.салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх;

33.1.3.хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах;

33.1.4.салбарын онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах албаны бүрэлдэхүүнийг тогтоох, мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангах;

33.1.5.гамшиг болон аюулын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах;

33.1.6.салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах;

33.1.7.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэх;

33.1.8.орон нутгийн гамшгаас хамгаалах албыг мэргэжлийн удирдлагаар хангах;

33.1.9.гамшиг болон аюулын нөхцөл байдлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх, хамтран ажиллах;

33.1.10.голомтын бүсэд ажиллах мэргэжлийн бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, материал хэрэгслийн хамт оролцуулах;

33.1.11.хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;

33.1.12.гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

33.1.13.гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаархи мэдээ, тайлан гаргах.



33.2.Гамшгаас хамгаалах улсын алба нь гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагчтай байна.

33.3.Орон нутгийн гамшгаас хамгаалах алба энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

34 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг

34.1.Хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшгаас хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ:

34.1.1.гамшгаас хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл авах;

34.1.2.гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, зөвлөгөө авах.

34.2.Хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшгаас хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

34.2.1.гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх;

34.2.2.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

34.2.3.үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;

34.2.4.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах;

34.2.5.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах;

34.2.6.гамшгаас хамгаалах орон нутгийн нөөц бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах;

34.2.7.гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, гамшиг болон аюулын нөхцөл байдлын тухай мэдээг дээд шатны байгууллага болон



онцгой байдлын байгууллагад цаг тухайд нь хүргэх, шаардлагатай бичиг баримт, бодит мэдээллээр хангах;

34.2.8.гамшиг болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргодох байрыг төхөөрөмжлөх, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах;

34.2.9.гамшигийн үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байх.

34.2.10.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөний улмаас гарсан зардлыг хариуцах.

35 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын эрх, үүрэг

35.1.Төрийн бус байгууллага нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараахь эрх, үүрэгтэй оролцоно:

35.1.1.гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн биелэлтэд иргэний хяналт тавих;

35.1.2.гамшигийн эрсдэлийг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хууль тогтоомж, зөвлөмж, арга зүй боловсруулахад оролцох;

35.1.3.гамшгаас хамгаалах судалгаа, сургалт, сурталчилгааг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

35.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэн, сайн дурын хэсэг, бүлэг, нөхөрлөлийн оролцоог идэвхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

35.1.5.онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллах.

36 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх, үүрэг

36.1.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг дараахь эрх, үүрэгтэй:

36.1.1.гамшгаас хамгаалах сургалтад хамрагдах;

36.1.2.гамшигийн үеийн үйл ажиллагаанд оролцоход шаардагдах багаж, хэрэгсэл, хүнсээр хангагдах;

36.1.3.онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардал, урамшуулал авах;



36.1.4.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг биелүүлэх;

36.1.5.гамшиг болон аюулын нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагад үнэн зөв, бодит, шуурхай мэдээлэл өгөх;

36.1.6.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд аюулгүй байдлаа хангаж оролцох.

36.2.Сайн дурын хэсгийн ажилтан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үед хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүнд онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ахлагчийн албан тушаалын зэрэглэлийн анхны шатлалын үндсэн цалингаар тооцон 2 жилийн, амь насаа алдсан бол түүний гэр бүлд 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

36.3.Сайн дурын хэсэг нь тухайн шатны Засаг даргад гамшгаас хамгаалах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаагаа тайлагнана.

36.4.Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

37 дугаар зүйл.Иргэний эрх, үүрэг

37.1.Иргэн гамшгаас хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ:

37.1.1.холбогдох байгууллага, албан тушаалтнаас аюулгүй байдлаа хангахад шаардлагатай арга хэмжээний талаар үнэн зөв мэдээлэл авах;

37.1.2.гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулах, гишүүнээр элсэх, гамшгаас хамгаалах дундын хөрөнгийн сан үүсгэх;

37.1.3.гамшигт өртсөн тохиолдолд шаардлагатай тусламж, дэмжлэг авах;

37.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дайчлагдан оролцох үед хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан бол энэ хуулийн 36.2-т заасан тусламж авах;

37.1.5.голомтын бүсэд дайчлагдан үндсэн ажлаас чөлөөлөгдөн үүрэг гүйцэтгэсэн бол цалин хөлсөө ажил олгогчоос, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нэгэн адил томилолтын зардлыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр авах.



37.2.Иргэн гамшгаас хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

37.2.1.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх;

37.2.2.гамшгаас хамгаалах сургалтад оролцох;

37.2.3.өдөр тутмын үйл ажиллагаандаа аюулгүй байдлыг хангах;

37.2.4.гамшиг болон аюулаас урьдчилан сэргийлэх, аврах арга, техник, багаж хэрэгслийг эзэмших, зарлан мэдээлэх дохиогоор ажиллах журмыг дагаж мөрдөх;

37.2.5.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох;

37.2.6.гамшиг болон аюулын тухай мэдээллийг холбогдох байгууллагад шуурхай, үнэн зөв хүргэх;

37.2.7.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөний улмаас гарсан зардлыг хариуцах.

НАЙМДУГААР БҮЛЭГ ГАМШГААС ХАМГААЛАХ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

38 дугаар зүйл.Дотоодын хүмүүнлэгийн тусламж

38.1.Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна.

39 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламж

39.1.Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн Улсын онцгой комисс олон улсын хүмүүнлэгийн тусламж авах саналыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

39.2.Олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал /цаашид “тусламж үзүүлэгч тал” гэх/ өөрийн дипломат төлөөлөгчийн байгууллагаар дамжуулан гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүсэлт гаргасан бол Засгийн газар уг тусламжийг авах эсэх талаар шийдвэр гаргана.

39.3.Тусламж үзүүлэгч тал нь тухайн улсын болон олон улсын байгууллагад бүртгүүлсэн байна.

39.4.Монголын улаан загалмай нийгэмлэг нь олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэг, холбоонд хандан гамшгаас



хамгаалах хүмүүнлэгийн тусламж хүсэх, хүлээж авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

40 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт

40.1. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль тогтоомж, заавар, удирдамжийн дагуу Улсын онцгой комисс зохицуулж, хяналт тавина.

40.2. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

40.3. Тусламж үзүүлэгч талын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

40.4. Тусламж үзүүлэгч тал дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

40.4.1. иргэдийг үндэс, угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах;

40.4.2. хувь хүний нууцыг задруулах;

40.4.3. гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдолгүй асуудалд оролцох, улс төрийн болон шашин шүтлэгийн байр суурийг илэрхийлэх;

40.4.4. санхүүгийн ашиг сонирхол хайх;

40.4.5. хүмүүнлэгийн тусламжтай хамааралгүй асуудлаар мэдээлэл цуглуулах;

40.4.6. олон улсын байгууллага болон гадаад улсын Засгийн газрын бодлогыг тулгах.

40.5. Тусламж үзүүлэгч талын бараа, үйлчилгээ нь Монгол Улсын хууль тогтоомж, нэрвэгдэгсдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

40.6. Тусламж үзүүлэгч тал нь бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмжийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд ашиглахгүй болох, аюултай хог, хаягдал үүсгэх тохиолдолд дахин боловсруулж ашиглах, эсхүл



байгаль орчинд ээлтэй аргаар устгах ажиллагааг холбогдох байгууллагын хяналтын доор өөрийн зардлаар гүйцэтгэнэ.

40.7.Тусламж үзүүлэгч талын мөнгөн хөрөнгөөр үзүүлэх тусламжийг хүлээн авах эсэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

40.8.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг Улсын онцгой комисс Засгийн газарт тайлагнана.

41 дүгээр зүйл.Олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зогсоох

41.1.Улсын онцгой комиссын саналыг үндэслэн Засгийн газар тусламж үзүүлэгч талын үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг гаргана.

41.2.Засгийн газар олон улсын хүмүүнлэгийн үйл ажиллагааг зогсоохоор бол энэ тухай шийдвэрийг тусламж үзүүлэгч талд 30 хоногийн өмнө дипломат шугамаар мэдэгдэнэ.

41.3.Тусламж үзүүлэгч тал нь энэ хуулийн 40.4-д заасан үйл ажиллагааг явуулсан нь тогтоогдвол Засгийн газрын шийдвэрээр тусламжийн үйл ажиллагааг шууд зогсооно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

42 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллага, түүний тогтолцоо

42.1.Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.

42.2.Онцгой байдлын байгууллага мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

42.3.Онцгой байдлын байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, соёл урлаг, спорт, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилтын болон бусад нэгжтэй байна.



42.4.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа нэгжийг засаг захиргаа, нутаг дэвсгэр, газар зүйн онцлог, хүн амын нягтрал, аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээг харгалзан Засгийн газрын шийдвэрээр байгуулна.

42.5.Онцгой байдлын байгууллагын төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.

43 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдэг

43.1.Онцгой байдлын байгууллага нь туг, бэлгэ тэмдэгтэй байна.

43.2.Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдгийн загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

43.3.Онцгой байдлын байгууллагын туг, бэлгэ тэмдгийг тус байгууллагаас бусад төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэн хэрэглэхийг хориглоно.

44 дүгээр зүйл.Онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэг

44.1.Онцгой байдлын байгууллага нь дараах үндсэн чиг үүрэгтэй:

- 44.1.1.гамшгаас урьдчилан сэргийлэх;
- 44.1.2.гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах;
- 44.1.3.гамшгийн хор уршгийг арилгах;
- 44.1.4.хойшлуулшгүй сэргээн босгох.

45 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагч

45.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай² болон Цэргийн албаны тухай хуульд³ заасан шаардлага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, боловсролын болон ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан иргэнийг авч ажиллуулна.

45.2.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль⁴, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.

²Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

³Цэргийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.

⁴Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.

45.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хязгаарлалт нэгэн адил хамаарна.

45.4.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын албан тушаалд онцгой байдлын албанд 10-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан алба хаагчийг томилно.

46 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцас, цол, таних тэмдэг

46.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ.

46.2.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, тэргүүн дэд даргад цэргийн дээд цол олгож болно.

46.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар тогтооно.

46.4.Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар, хэрэглэх журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

46.5.Онцгой байдлын байгууллагад цэргийн цолыг хэрэглэх, олгох, бууруулах, хураан авах, сэргээх харилцааг Цэргийн албаны тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу зохицуулна.

47 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх

47.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна дараахь эрх эдэлнэ:

47.1.1.гамшиг болон аюулын үед үүрэг гүйцэтгэх болон сургалт, дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах;

47.1.2.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор шаардлагатай объектод саадгүй нэвтрэх.



48 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүрэг

48.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хүлээнэ:

48.1.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, оролцох;

48.1.2.аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд сахих, байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх;

48.1.3.хариуцсан техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

49 дүгээр зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох тэтгэвэр, тэтгэмж

49.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд⁵ заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авна.

49.2.Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.

49.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.

50 дугаар зүйл.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа

50.1.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно.

⁵Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.



50.2.Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.

50.3.Албан үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцна.

50.4.Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдана.

50.5.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно.

50.6.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

50.7.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна.

50.8.Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.

50.9.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиас доошгүй байна.

**АРАВДУГААР БҮЛЭГ
ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ**

**51 дүгээр зүйл.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны
санхүүжилт**

51.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана.



51.2.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилийн төсвийн 1.0 хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулна.

51.3.Аймаг, нийслэл, сум дүүрэг нь тухайн жилийн төсвийн 1.0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна.

51.4.Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

52 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

52.1.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2003 оны 06 дугаар сарын 20-ны өдөр баталсан Гамшгаас хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.20 дахь хэсэг нэмсүгэй:

“15.20. Гамшгаас хамгаалах чиглэлээр:

15.20.1. гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл болон аюулын улмаас” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “Байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, гал түймэр зэрэг



гэнэтийн аюул” гэснийг “Гамшиг, аюулт үзэгдэл болон аюул” гэж, мөн зүйлийн 14.1.1 дэх заалтын “улсын байнгын онцгой комиссын” гэснийг “Улсын онцгой комиссын” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “байгалийн гамшиг, сүйрлийн хор хөнөөлийг” гэснийг “гамшгийн хор уршгийг” гэж, мөн зүйлийн 7.4 дэх хэсгийн “байгалийн гамшиг, түймэр, усны үерт” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэлд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “байгалийн гамшиг, түймэр,” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл,” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “байгалийн гамшиг болон бусад аюулд” гэснийг “гамшигт, аюулт үзэгдэлд” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “байгалийн гамшигт” гэснийг “гамшигт” гэж тус тус өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**АРХИВЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Архивын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “байгалийн гамшиг, гал усны болон гэнэтийн бусад аюул” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “байгалийн болон нийтийг хамарсан” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтын “байгалийн бусад” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “байгалийн гамшигт үзэгдэлтэй” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюултай” гэж, мөн зүйлийн 3.1.10 дахь заалтын “байгалийн гамшигт үзэгдлийн” гэснийг “гамшиг болон аюулын” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “байгалийн гамшиг, ослын” гэснийг “гамшиг, аюулт



үзэгдлийн” гэж, 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийн “Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл, ослын” гэснийг “Гамшиг, аюулт үзэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Газрын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулд нэрвэгдэж,” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осолд нэрвэгдэж,” гэж, 52 дугаар зүйлийн 52.8 дахь хэсгийн “Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас” гэснийг “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас” гэж, мөн зүйлийн 52.9 дэх хэсгийн “Ган, зуд болон бусад байгалийн гамшиг” гэснийг “Гамшиг, аюулт үзэгдэл” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарах зэрэг нөхцөлд” гэснийг “гамшиг болон аюул үүсэх нөхцөлд” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Дипломат албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “байгалийн гэнэтийн аюул, гамшиг бий болох,” гэснийг “гамшиг болон аюул үүсэх,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон” гэснийг “гамшиг болон аюул тохиолдсон” гэж, 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үр дагаврыг арилгах” гэснийг “гамшгийн хор уршгийг арилгах” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтын “хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл” гэж, 25¹ дүгээр зүйлийн 25¹.2.2 дахь заалтын “нийтийг хамарсан байгалийн гамшиг, технологийн осол аюулын үед,” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул бий болсон үед,” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30² дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон,” гэснийг “Гэмт хэрэг гарсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул бий болсон” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол үүссэн” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “иргэний хамгаалалтын албатай” гэснийг “онцгой байдлын байгууллагатай” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2 дахь заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул,” гэснийг, мөн зүйлийн 4.5.9 дэх заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн аюул,” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл,” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2.9 дэх заалтын “байгалийн гамшгаас” гэснийг “гамшгаас” гэж, 15 дугаар зүйлийн 15.4.2 дахь заалтын “малын гоц халдварт өвчний голомтод болон байгалийн гамшгийн үед” гэснийг “голомтын бүс болон гамшгийн үед” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.9 дэх заалтын “ган, зуд зэрэг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.6.б дэд заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хүн, мал, амьтныг аврах, нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх,” гэснийг “гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх,” гэж, мөн заалтын “гэнэтийн аюулын бусад үр дагаврыг” гэснийг “гамшгийн хор уршгийг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Байгалийн аюул гамшиг,” гэснийг “Гамшиг болон аюул,” гэж, 13 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох” гэснийг “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “, урьдчилан сэргийлэх” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, гоц халдварт өвчин,” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл болон аюул,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“34.1.Олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан үрэгдэх, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд их хэмжээний хохирол учруулахуйц гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн тохиолдолд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулан иргэний өмчийн газрыг хуульд заасан журмын дагуу аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын шийдвэрээр түр хугацаагаар дайчлан авч болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “гамшигт өртөгсдөд анхны тусламж үзүүлэх, байгалийн гамшиг, гэнэтийн осол, нийтийг хамарсан гоц аюулт халдварт өвчинд нэрвэгдэгсдэд” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “аюул осол, сүйрэлд өртсөн, нэрвэгдсэн энгийн иргэнд” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осолд нэрвэгдэгсдэд” гэж, мөн зүйлийн 12.3 дахь хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн осол, сүйрэл тохиолдсон, нийтийг хамарсан гоц аюулт халдварт өвчин гарсан үед” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Номын сангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул,” гэснийг “гамшиг болон аюул,” гэж, мөн зүйлийн 20.5, 20.6 дахь хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед” гэснийг “гамшиг болон аюулын үед” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4 дэх заалтын “байгалийн гамшиг, гал түймэр зэрэг гэнэтийн аюулд” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осолд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Байгалийн гамшиг, ой, хээрийн түймэр, ойн хөнөөлт шавж, өвчинд” гэснийг “Гамшиг, аюулт үзэгдэлд” гэж, 18 дугаар зүйлийн 18.3.11 дэх заалтын “ойг ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж өвчин зэрэг байгалийн гэнэтийн аюул,” гэснийг “ойг аюулт үзэгдэл,” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онц байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул /газар хөдлөлт, хүчтэй салхи, ган, зуд, үер, түймэр, цацраг идэвхт болон химийн хорт бодисын хордуулалт, хүн, малын гоц халдварт өвчин зэрэг/” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН
ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах,” гэснийг “гамшгийн хор уршгийг арилгах,” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтын “байгалийн гамшиг, төмөр замын сүйрэл, осол, гологдлын хор уршгийг арилгах” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийн “байгалийн гамшиг, гал түймэр, осол, сүйрэл, гологдлын хор уршгийг арилгах” гэснийг, мөн зүйлийн 25.6, 25.8 дахь хэсгийн “байгалийн гамшиг, осол, сүйрэл, гологдлын хор уршгийг арилгах” гэснийг “гамшиг, ослын болон гологдлын хор уршгийг арилгах” гэж тус тус өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 10, 15 дугаар зүйлийн “байгалийн гамшгаас учирсан хор уршгийг” гэснийг “гамшгийн хор уршгийг” гэж, 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас” гэснийг “гамшиг болон аюулаас” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “байгалийн гамшиг, хүн, малын гоц халдварт болон ургамлын онц хөнөөлт өвчинтэй” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэлтэй” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын нөөцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.1.4. “гамшгийн нөөц” гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материалыг;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “байгалийн болзошгүй гамшиг,” гэснийг “аюул болон” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “байгалийн гамшиг” гэснийг “аюулт үзэгдэл, гамшиг” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтын “байгалийн гамшгийн улмаас учирсан хохирлыг” гэснийг, мөн зүйлийн 7.2.2 дахь заалтын “байгалийн гамшгаас учирсан хохирлыг” гэснийг “аюулт үзэгдэл, гамшгийн хохирлыг” гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “байгалийн гамшгаас сэргийлэх мэдээний” гэснийг “аюулт үзэгдэл, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээний” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “Байгалийн гамшгийн тухай” гэснийг “Аюулт үзэгдэл, гамшгийн тухай” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “байгалийн гамшгийн тухай” гэснийг “аюулт үзэгдэл, гамшгийн тухай” гэж, 16 дугаар зүйлийн 16.1.6 дахь заалтын “байгалийн гамшигтай холбогдсон” гэснийг “аюулт үзэгдэл, гамшигтай холбогдсон” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг “гамшиг болон аюул үүссэн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “Байгалийн гамшиг, давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас учирсан хор уршгийг арилгах,” гэснийг “Гамшгийн хор уршгийг арилгах,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан

сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах” гэснийг “Гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах” гэж, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийн “Байгалийн болон нийтийг хамарсан гамшиг,” гэснийг “Гамшиг болон аюул үүссэн,” гэж, 74 дүгээр зүйлийн 74.2.2 дахь заалтын “байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрлэлийн ослоос” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, ослоос” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “байгалийн гамшиг, гоц халдварт өвчин, гэнэтийн бусад аюул” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын “байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1 дэх заалтын “байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гэнэтийн аюул,” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул,” гэж, 107 дугаар зүйлийн 107.5 дахь хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсоны улмаас” гэснийг “гамшиг болон аюул үүссэний улмаас” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.7 дахь заалт, 146 дугаар зүйлийн 146.2 дахь хэсгийн “нийтэд учирсан гамшигт байдал,” гэснийг “гамшиг,” гэж, 145 дугаар зүйлийн 145.3 дахь хэсгийн “нийтэд учирсан гамшигт байдлыг” гэснийг “гамшгийг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн “байгалийн” гэснийг, 304 дүгээр зүйлийн 304.1 дэх хэсгийн “байгалийн” гэснийг тус тус хассугай.



3 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/-д
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 4.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “байгалийн гамшигт” гэснийг “гамшигт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 332 дугаар зүйлийн 332.1.3 дахь заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон,” гэснийг “гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17.1.2-т заасан эрүүл мэндийн алба мөн хуулийн 18.1.1-д заасны дагуу зохион байгуулна.” гэснийг “Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу байгуулагдсан гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба мөн хуульд заасны дагуу зохион байгуулна.” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтын “байгалийн болон бусад гамшигт өртсөн” гэснийг “гамшиг болон аюулд өртсөн” гэж, “байгалийн гамшгийн” гэснийг “гамшгийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийн “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон,” гэснийг “гамшиг болон аюул тохиолдсон,” гэж, 103 дугаар зүйлийн 103.1.1 дэх заалтын “байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон” гэснийг “гамшиг болон аюул тохиолдсон” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 6

Индекс: 200003